

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН  
2021 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2021.05.03

Сүхбаатар сум

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:**

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны талаар:**

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2021 оны 04 дүгээр сард 1 удаа цахимаар хуралдаж 15 асуудал хэлэлцэн 9 тогтоол баталлаа. Үүнд:

1.Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги батлах тухай асуудлыг хэлэлцээд 7 зорилтын 65 ажил арга хэмжээтэйгээр баталлаа.

2.Журам батлах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажиллах журам”-ыг шинэчлэн баталж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 102 дугаар тогтоолыг хүчингүйд тооцлоо.

3. “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр”-ийн 1 дүгээр үе шатны хэрэгжилтийг хэлэлцээд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2017-2020 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг “Хангалттай” гэж дүгнэлээ.

4.2021 онд аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэн баталлаа.

5.Сэлэнгэ аймгийн 17 сумын 57 багийн нэрийг хавсралтад дурдсан нэрээр Монгол Улсын Их Хурлаар батлуулахаар дэмжин уламжиллаа.

6.Тооны дээд хязгаар тогтоох тухай асуудлыг хэлэлцээд Сэлэнгэ аймагт 2021 онд цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн тооны дээд хязгаарыг 30 иргэн байхаар тогтоов. Тодруулбал, Мандал суманд 10, Зүүнбүрэн суманд 10, Баянгол суманд 5, Сант суманд 5 байхаар тогтоолоо.

7.Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай асуудлыг хэлэлцээд Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Эрүүл мэндийн төвийн балансад бүртгэлтэй 275.374.654.28 төгрөгийн үнэ бүхий хуучин Эрүүл мэндийн төвийн барилга байгууламж, газар, нийтийн эзэмшлийн байгууламж зэргийг аймгийн Онцгой байдлын газрын Хүдэр сум дахь Эрэх хайх, аврах салбарт шилжүүлэхийг зөвшөөрөв.

8.Шаамар сумын Дулаанхаан тосгоны үүсэн байгуулагдсаны 60 жилийн ойг 2021 оны 07 дугаар сарын 02-03-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлэхийг зөвшөөрч, ой тэмдэглэх бэлтгэл зохион байгуулалтын ажилд /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлж халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөн ажиллахыг даалгалаа.

9.Боловсролын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан Мандал сумын иргэн, ахмад багш Балсангийн Уунайг Гавьяат багш цолоор, соёл урлагийн салбарт үр бүтээлтэй ажилласан Сүхбаатар сумын харьяат СУИС-ийн Сонгодог урлагийн тэнхимийн багш Балжиннямын Баттөрийг Гавьяат жүжигчин цолоор, биеийн тамир, спортын салбарт үр бүтээлтэй ажилласан Сүхбаатар сумын иргэн, аймгийн БТСГ-ын ахмад ажилтан Данзангийн Эрдэнэбатыг Гавьяат дасгалжуулагч цолоор, эрхэлсэн

ажилдаа амжилт гаргасан зарим хүмүүсийг одон, медалиар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжиллаа.

10.Коронавируст халдварт “Covid-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэх ажлын явц, үр дүнгийн тухай аймгийн Эрүүл мэндийн газрын даргын мэдээлэл

11.Санхүүгийн хяналт шалгалтын үр дүн, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаарх аймгийн Санхүүгийн хяналт, Дотоод Аудитын албаны даргын мэдээлэл

12. Мал төллөлт, хаврын тариалалтын бэлтгэл ажлын талаарх аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын мэдээллүүдийг сонслоо.

### **Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:**

БНСУ-ын Жежү мужаас зохион байгуулж буй “Газар, орон нутгийн соёл” сэдэвт Олон Улсын гэрэл зургийн уралдааныг аймгийн хэмжээнд зохион байгууллаа.

Төрийн байгууллага, албан тушаалтанд иргэдээс гаргасан санал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2021 оны 1 дүгээр улирлын тайланг ЗГХЭГ-т хүргүүлж ажиллалаа. 1 дүгээр улиралд аймгийн хэмжээнд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд нийт **1367** иргэн хандаж санал, хүсэлт, өргөдөл, гомдол гаргаснаас **1186** иргэний өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн нь **87** хувийн үзүүлэлттэй байна.

Улсын хэмжээнд коронавируст /Covid-19/-ын халдварын тохиолдол дотоодод бүртгэгдэж Засгийн газрын тогтоолоор бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан аймаг, сум, хот хоорондын зорчих хөдөлгөөнийг хаасан хугацаанд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хот хооронд болон аймаг, сум дотроо зорчих хүсэлт, өргөдлөө бичгээр гаргасан 646, аймгийн Онцгой комиссын шуурхай штабт хандсан 467, нийт 1113 иргэний хүсэлтийг тус тус бүртгэлжүүлэн шийдвэрлэж ажилласан байна.

Төрийн албаны зөвлөлөөс долоо хоног бүрийн “Пүрэв” гарагт тодорхой сэдвийн хүрээнд төрийн албан хаагчдыг чадавхжуулах цахим сургалтыг зохион байгуулж байна. 04 дүгээр сард Харилцаа, холбоо мэдээллийн технологийн газартай хамтран зохион байгуулсан “E-Mongolia” цахим үйлчилгээний системийн танилцуулга, “Кибер орон зай дахь аюулгүй байдал”, “Орчин үеийн техник, технологийн чиг хандлага: Виртуал орчинд ажиллах”, Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран зохион байгуулсан Төрийн албаны шинэтгэлийн үзэл санаа, онол практикийн асуудлыг багтаасан “Төрийн алба:Шинэтгэлд шимтэхийн учир” номын танилцуулга сургалтад аймгийн Төрийн албаны Зөвлөлийн Салбар зөвлөлийн гишүүд, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар болон аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, албадын холбогдох мэргэжилтэн, албан хаагчдыг хамруулах арга хэмжээг авч ажиллалаа.

Төрийн албаны зөвлөл, Үндэсний статистикийн хороотой хамтран зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгаа”-г аймгийн хэмжээнд зохион байгууллаа. Судалгаанд аймгийн хэмжээнд 6194 төрийн албан хаагч хамруулахаар нэрсийг ирүүлснээс жирэмсний амралттай, ажлаас чөлөөлөгдсөн, тэтгэвэрт гарсан, нэр давхардсан гэх мэт шалтгааны улмаас 248, Сэлэнгэ аймгийн харьяат хэдий ч өөр аймаг орон нутагт ажиллаж буй 170 албан хаагчийн нэрсийг судалгааны хүрээнээс хасуулж, 17 сум 6 тосгоны 239 төрийн байгууллагын 5777 албан хаагчийг судалгаанд хамруулж, хамрагдалт 100 хувьтай байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас цахимаар зохион байгуулж буй “**Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ**” сургалтад төр, төсвийн нийт 1100 гаруй албан хаагч хамрагдаж, гэрчилгээ авсан.

**Аймгийн Онцгой комиссын үйл ажиллагааны талаар:**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Улсын Онцгой комиссын хуралдааны тэмдэглэл, тогтоол, тушаал, Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга нарын баталсан тушаал шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн Онцгой комисс 16 удаа хуралдан 42 асуудлыг хэлэлцэж 165 асуудлыг шийдвэрлэн аймгийн Засаг даргын захирамж 1, тогтоол 5, хурлын 16 тэмдэглэл гаргасан.

Мөн Гамшгаас хамгаалах хууль тогтоомж болон Засгийн газар, Улсын Онцгой комиссоос өгсөн үүрэг чиглэл, аймгийн Онцгой комиссын хуралдаанаар гарсан шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд сум, агентлаг, байгууллагуудад нийт 1410 албан тоотоор үүрэг чиглэл, зөвлөмж, шаардлага, хүсэлтийг хүргүүлж, 1860 албан бичгийн бүртгэл хөтлөн хүлээн авч, албан бичгээр ирсэн тайлан мэдээг боловсруулан нэгтгэж өдөр тутмын нөхцөл байдлын мэдээнд тусгуулах, ирүүлсэн хүсэлтүүдийг холбогдох ажлын хэсэгт хүргэн шийдвэрлүүлэн, аймгийн хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллаж байна.

Шуурхай штабын 70363684, 70360119 дугаарын утсанд 885 мэдээлэл, цахим хаягаар 1780 албан бичиг, гар өргөдөл 42 нийт 2707 мэдээллийг хүлээн авч шийдвэрлэсэн байна.

**Авч хэрэгжүүлж буй арга хэмжээний чиглэлээр:** Аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудас болон Онцгой байдлын газрын цахим пэйж хуудсанд 104 удаа мэдээ мэдээлэл байршуулж 128252 хандалтыг авсан. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн өдөрт 2 удаагийн давтамжтайгаар 12:00,17:00 цагуудад нөхцөл байдлын талаарх мэдээлэл бэлтгэн аймгийн Засаг даргын Тамгын газраас “Сэлэнгэ аймаг АЗДТГ”, “Сэлэнгэ Цахим телевиз” цахим хуудас, Зиндаа.мн сайт, Улс төрч.мн сайт, Сүхбаатар сум дахь лед дэлгэц, орон нутгийн “Миний Монгол ТВ”, “Таны Сэлэнгэ ТВ” мөн МҮОНТ-ийн ММ агентлаг, Өлзий телевиз, Монцамэ агентлаг зэрэг мэдээллийн сувгуудаар мэдээ, мэдээллийг дамжуулан. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын Онцгой комиссын шуурхай штаб, Онцгой байдлын ерөнхий газарт тухай бүр мэдээлэл хүргүүлэн ажиллаж байна.

**Эрүүл мэндийн чиглэлээр:** Аймгийн хэмжээнд 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар 5 тусгаарлан ажиглах байранд 340 иргэн тусгаарлан ажиглалтад байна. Тусгаарлан ажиглах 3 байрнаас 5 тохиолдол батлагдсан. Орон нутагт ойрын хавьтал болох 1114 иргэн гэрийн тусгаарлалтад, дам хавьтал болох 1178 иргэн гэрийн ажиглалтад байна.

Аймгийн хэмжээнд 04 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн вакцинжуулалтын үйл ажиллагаа эхэлсэн. Нийт 32 цэг 128 эмч эмнэлгийн ажилтан ажиллаж 14732 эрүүл мэндийн салбар, хариу арга хэмжээний баг, стратегийн ач холбогдол бүхий салбарын алба хаагчдыг дархлаажуулалтад амжилттай хамруулсан. 04 дүгээр сарын 23-ны өдөр /КОВИД-19/-ийн эсрэг дархлаажуулалтыг үргэлжлүүлэхээр БНХАУ-ын Синофарм үйлдвэрийн вакцины 2 дахь тунгийн татан авалтыг хийхээр дархлаажуулалтын баг ажиллаж байна.

**Хэв журам, замын хөдөлгөөн хязгаарлалтын чиглэлээр:** Энэ хугацаанд нийт 50 иргэнийг тусгаарлах байрны хамгаалалтад авч давхардсан тоогоор 930 хоног 36 хяналтын цэгт 6459 тээврийн хэрэгсэлтэй Цагдаагийн газрын албан хаагч 120 тээврийн

хэрэгсэлтэй, Онцгой байдлын газрын 320 алба хаагч, Эрүүл мэнд, эмнэлгийн байгууллагын 480, Мэргэжлийн хяналтын газрын 110 бусад төрийн байгууллагуудтай хамтран нийт 1030 албан хаагч үүрэг гүйцэтгэсэн.

**Улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлсэн талаар:** Улсын Онцгой комиссын тогтоол, шийдвэрийн дагуу Монгол Улсын хилээр нийт 6 орны 1844 зорчигч, 8 орны 1679 тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу шалган нэвтрүүлсэн.

Аймгийн хэмжээнд 04 дүгээр сарын 01-28-ны өдөр хүртэл орох чиглэлээр нийт 2046 тээврийн хэрэгслээр 4194 иргэн орсон. Үүнээс хувийн 1554 автомашинаар 3527 иргэн, албан томилолтоор 53 машинаар 101 иргэн, бусад /ачаа тээвэр, эмнэлэг/ 473 тээврийн хэрэгсэл орсон. Гарах чиглэлээр нийт 1376 тээврийн хэрэгслээр 2167 иргэн гарсан. Үүнээс хувийн 866 автомашинаар 1689 иргэн, албан томилолтоор 3 тээврийн хэрэгслээр 5 иргэн, бусад /ачаа тээвэр, эмнэлэг/ 505 тээврийн хэрэгсэл гарсан байна.

Татан авалтаар 04 дүгээр сарын 01-28-ны өдрүүдэд нийт 2 нийтийн тээврийн хэрэгслээр БТЕГ-ын уурхайн ажилчин 84 иргэн /PCR шинжилгээнд хамрагдсан/ орсон. Гарах чиглэлд 2 нийтийн тээврийн хэрэгсэл хүнгүй буцсан. УОК-ын даргын баталсан 2021 оны 22 дугаар “Хот хоорондын зорчигч тээвэрлэлтийг зохицуулах түр журам”-ын хэрэгжилтийг хангуулан нийтийн тээврээр зорчин ирсэн иргэдийн бүртгэлийг хөтлөн, тээвэрлэлт гүйцэтгэсэн 2 автобусыг халдваргүйтгэл хийж буцаасан.

Зөрчлийн арга хэмжээг ангилж үзвэл: Онцгой байдлын газар нийт 3 гомдол мэдээллийг хүлээн авч 4 иргэнийг 100,000 төгрөгөөр нийт 400,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан байна.

Аймгийн хэмжээнд 04 дүгээр сард голомтын халдваргүйжүүлэлтийг 90 айл өрх, 76 худалдаа үйлчилгээний газар, 164 /бусад/ байгууллага, нийт 330 объектод 91077 метр квадрат талбайд ЗӨСТ, Мандал сумын нэгдсэн эмнэлэг голомтын халдваргүйжүүлэлтийг хийсэн.

04 дүгээр сарын 28-ны өдрийн 20 цагийн байдлаар нийт өссөн дүнгээр Сэлэнгэ аймгийн хэмжээнд коронавируст халдвар батлагдсанаас хойш ПГУ-58748 түргэвчилсэн-65684 нийт 124432 иргэнийг шинжилгээнд хамруулсан байна.

Түшиг суманд коронавируст халдварын тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан сумын иргэдээс шинжилгээ авах 10 багийн нийт 30 эмч, эмнэлгийн ажиллагсад халдвар хамгааллын дэглэм баримтлан, анхаарах асуудлын хүрээнд дадлагад суурилсан сургалтыг аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран зохион байгуулан ажилласан.

04 дүгээр сарын 01-ний өдрөөс өссөн дүнгээр 442.64 кг аюултай хог хаягдлыг Нэгдсэн эмнэлгийн аюултай хог хаягдал боловсруулах төвлөрсөн барилга байгууламжид хүлээн авч автоклавт оруулан ариутгал хийж аюултай хог хаягдлын цэгт булсан, 2648.054 кг аюултай хог хаягдлыг халдваргүйжүүлж шатаасан.

Эрүүл мэндийн сайдын ЭМС-ын 2017 оны А/505 тоот тушаалын дагуу нийт 3751.444 кг аюултай хог хаягдлыг ахуйн гаралтай хог хаягдлын цэгт шатааж булшлан устгал хийх явцад халдвар хамгааллын дэглэмд хяналт тавьж ажилласан.

#### **Аймгийн сонгуулийн хорооны үйл ажиллагааны талаар:**

Монгол Улсын сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 03 дугаар сарын 29-ний “Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо байгуулах тухай” 40 дүгээр тогтоолын дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах Сэлэнгэ аймгийн Сонгуулийн хороог 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, Сэлэнгэ аймгийн Сонгуулийн хорооны 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн “Төлөвлөгөө батлах

тухай” 02 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийг Сэлэнгэ аймагт зохион байгуулах аймгийн Сонгуулийн хорооны ажлыг төлөвлөгөөг батлан төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулан ажиллаж байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагааны зохион байгуулалт цахим сургалтыг зохион байгуулж сургалтад аймаг, нийслэлийн сонгуулийн хороодын дарга нарийн бичгийн дарга, гишүүд, Сонгуулийн ерөнхий хорооны дарга нарийн бичгийн дарга, Ажлын алба, Мэдээллийн технологийн төвийн албан хаагчид оролцлоо.

#### **Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар:**

Коронавируст халдвар /COVID-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хор уршгийг арилгах ажлыг зохион байгуулах зорилгоор аймгийн Онцгой комиссын шуурхай штаб-т тус газрын 8 алба хаагч өдөр бүр ажиллан иргэдэд утсаар заавар зөвлөмж өгөх, сумдын Онцгой комиссын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн харилцан уялдааг хангах, аймгийн Онцгой комиссын хуралдааныг зохион байгуулан Засгийн газар, Улсын Онцгой комиссоос гарсан тогтоол шийдвэрүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Сүхбаатар, Шаамар, Баянгол, Мандал, Сайхан, сумдын автозамын хяналтын цэгүүдэд алба хаагчид үүрэг гүйцэтгэн хөдөлгөөн үйлдэж буй иргэдээс шинжилгээ авах, бүртгэлжүүлэх, халдвар хамгааллын дэглэм сахиулах зэрэг үүргүүдийг гүйцэтгэн ажиллаж байна.

Монгол Улсын Шадар сайдын зах худалдааны барилга, байгууламжийн галын аюулгүй байдлын хяналт шалгалтыг зохион байгуулсан. Хяналт шалгалтын хүрээнд 11 барилга байгууламж хамрагдан 33 зөрчил илрүүлж, холбогдох арга хэмжээг авч, хяналт тавин ажиллаж байна.

2021 оны 04 дүгээр сарын байдлаар объектын гал түймрийн 9, хээрийн түймрийн 1 дуудлага тус тус ирж тухай бүр богино хугацаанд хор уршгийг арилган ажилласан.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай” 02 дугаар албан даалгавар, Онцгой байдлын газрын даргын баталсан “Гал түймрийн аюулгүй байдлыг хангуулах” нэгдсэн арга хэмжээний хүрээнд “Дэлхийн Зөн Монгол” ОУ-ын байгууллагын “Сэлэнгэ Орон Нутгийн Хөтөлбөр”-тэй хамтран объектын болон ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор Сүхбаатар суманд УБ-СБ чиглэлийн төв зам дагуу “Эж мод”-ны салдаг хэсэгт мөн Онцгой байдлын газрын урд, төв зам дагуу, Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Сүхбаатар сумын Ган зам 7 дугаар баг 7-р хэсэг хувьсгалчдын 1-р хэсэгт урьдчилан сэргийлэх самбарыг тус тус байршууллаа.

Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор 3 сэрэмжлүүлэг шторкыг дохионы хэлний орчуулгатайгаар бэлтгэж аймгийн Засаг даргын Тамгын газар, Миний Монгол телевиз, Онцгой байдлын газрын цахим сайт болон пэйж хуудсанд байршуулан ажиллалаа.

#### **Мэргэжлийн хяналтын үйл ажиллагааны талаар:**

Аймгийн хэмжээнд 04 дүгээр сард голомтын халдваргүйжүүлэлтийг 90 айл өрх, 76 худалдаа үйлчилгээний газар, 164 /бусад/ байгууллага, нийт 330 объектод 91077 м2 талбайд ЗӨСТ, Мандал сумын нэгдсэн эмнэлэг голомтын халдваргүйжүүлэлтийг хийхэд МХГ-аас хяналт тавьж ажиллалаа.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг болон Мандал сумын Нэгдсэн эмнэлэг, 6 эрүүл мэндийн төвд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж, шалгалтын явцад 6 зөрчлийг илрүүлж газар дээр нь 2 зөрчлийг арилгуулж, зохион байгуулалттай холбоотой 2, хүний нөөцийн хүрэлцээ хангалтгүй 1, яаралтай тусламж үзүүлэх бэлэн байдлыг хангаагүй 1, нийт 4 зөрчил дутагдлыг арилгуулахаар 1 албан шаардлагыг хугацаатай өгч биелэлтийг тооцож ажиллахаар шийдвэрлээд байна.

Аймагт халдварын тохиолдол бүртгэгдэж тусгаарлан ажиглах, эмчлэх үйл ажиллагааг эхлүүлсэнтэй холбогдуулан тусгаарлан ажиглах байр болон ковидын тасагт эмчлүүлж буй иргэдэд өгч буй өдрийн хоолны илчлэг тодорхойлох зорилгоор 8 нэр төрлийн боловсруулсан бүтээгдэхүүнээс дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээнд хамруулахад эрүүл ахуйн хими, хор судлалын хяналтын лабораторийн 04 дүгээр сарын 12-ны өдрийн 21-276 дугаар шинжилгээний дүнгээр өдрийн хоолны илчлэг 4999.44 ккал буюу Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралтад тусгагдсан шаардлагыг хангасан байна.

Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 18 дугаар тушаалаар батлагдсан “Коронавируст халдвараас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”, аймгийн Онцгой комиссын 2021 оны 08 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах зорилгоор МХЕГ-ын 01/48 тоот удирдамжийн дагуу үсчин, гоо сайхан, хумс заслын 64, нийтийн халуун ус, саун, бассейн 10, зочид буудал, дэн буудал 8, нийтийн тээврийн 15, хүнсний үйлдвэр 1, хүнсний худалдаа 175, нийтийн хоол үйлдвэрлэл, хүргэлтийн үйлчилгээний 14, хүнсний бус бараа бүтээгдэхүүний 61 нийт 348 объектын үйл ажиллагаанд тавигдах тусгай нөхцөл шаардлагад зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 18 дугаар тушаалаар батлагдсан “Коронавируст халдвараас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”, аймгийн Онцгой комиссын 2021 оны 08 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах зорилгоор МХЕГ-ын 01/48 тоот удирдамжийн дагуу үсчин, гоо сайхан, хумс заслын 64, нийтийн халуун ус, саун, бассейн 10, зочид буудал, дэн буудал 8, нийтийн тээврийн 15, хүнсний үйлдвэр 1, хүнсний худалдаа 175, нийтийн хоол үйлдвэрлэл, хүргэлтийн үйлчилгээний 14, хүнсний бус бараа бүтээгдэхүүний 61 нийт 348 объектын үйл ажиллагаанд тавигдах тусгай нөхцөл шаардлагад зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, улсын байцаагчийн 14 төрлийн зөвлөмжийг 191 объектод хүргүүлж, 348 объектод 402 иргэнд мэргэжил арга зүйн зөвлөгөө зөвлөмжийг өгч, дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлж ажиллах талаар “Хөгжлийн шийдэл” ТББ-тай хамтран 5 сумын 10 аж ахуйн нэгжийн төлөөлөлд цахим хэлбэрээр сургалтыг зохион байгуулж ажилласан.

МХЕГ-ын даргын баталсан 01/05 дугаартай удирдамжийн дагуу аймгийн хэмжээнд 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2 хүнсний үйлдвэр, 19 худалдаа үйлчилгээний газар, 12 хүнсний тээвэрлэлт, 6 түгээлт, 1 хоол үйлдвэрлэлийн нийт 40 объектод урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийлээ.

Шалгалтын явцад 83 зөрчлийг илрүүлж, 26 буюу 31.3 хувийг газар дээр нь арилгуулж зөрчил дутагдлыг арилгуулах талаар 33 заалттай 4 албан шаардлагыг хугацаатай өгч биелэлтийг тооцоход 75 хувьтай хангагдсан байна. Мөн МХГ-ын даргын 2 албан мэдэгдэл, улсын байцаагчийн 3 зөвлөмжийг бүх сумдын Засаг дарга нарт цахимаар хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

#### **Стандартчилал, хэмжил зүйн үйл ажиллагааны талаар:**

Гэрэл зургийн үйлчилгээ ерөнхий шаардлага MNS 5376:2004, хувцас захиалга, засварын үйлчилгээ ерөнхий шаардлага MNS 5636:2006 стандартаар хийх тохирлын

үнэлгээний хуудсыг баталгаажуулалтын шинэ загварт оруулан шинэчлэн боловсруулсан.

Бүтээгдэхүүний баталгаажуулалтаар Сайхан сумын 1-р багт байрлах “Хөтөл Дээжис” цехийн бялуун бүтээгдэхүүнийг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн сорилтын лабораторит сорилт шинжилгээнд оруулж баталгаажуулалт хийж тохирлын гэрчилгээ олгов. Мөн Сүхбаатар сумын 7-р багт байрлах “Залуу Сэлэнгэ” ХХК-ий үйлдвэрлэсэн 2 нэрийн 6 бүтээгдэхүүн, Мандал 6-р багт байрлах “Заяат” талхан цехийн 1 нэрийн 1 бүтээгдэхүүнд тус тус тохирлын гэрчилгээ олгов.

Үйлчилгээний баталгаажуулалтаар Хушаат, Сүхбаатар, Сайхан, Хүдэр, Баянгол, Ерөө, Мандал, Шаамар сумын 36 аж ахуйн нэгжийн 40 үйлчилгээний газарт тохирлын үнэлгээ хийж, МУ-ын “Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5021-1:2019”, “Хоолны газрын үйлчилгээ Ерөнхий шаардлага MNS 4946:2019”, “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ Дэн буудалд тавих шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлага хангасан 34 иргэн, аж ахуйн нэгжийн 38 үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээ олгож ажиллалаа.

Стандарт, мэдээллийн салбар сангаас 8 аж ахуй нэгж, байгууллага иргэний захиалгын дагуу 4 нэрийн 8 стандартын борлуулалт хийж, арга зүйн зөвлөмж өгч, “Спирт бал бурам” ХХК-тай 2021 оны “Хэмжих хэрэгсэл баталгаажуулах гэрээ” байгуулж ажиллалаа.

Эзлэхүүн хэмжлийн төрлөөр: Дулаанхан тосгоны “Тэс петролиум” ШТС-ын 4 шатахуун түгээгүүр, “МТЧ” ШТС-ын 1 түгээгүүр шалган баталгаажуулсан.

Механикийн хэмжлийн төрлөөр: Сүхбаатар суманд худалдаа үйлчилгээ эрхэлдэг иргэдийн 32 жин, “Хөдөө аж ахуйг дэмжих сан” Сэлэнгэ салбарын 100 тонны авто машины жин, элваторын 1 жинг тус тус шалгаж, баталгаажуулав.

Дулаан даралтын хэмжлийн төрлөөр: 6 термометр, 71 даралтын аппарат тус тус баталгаажуулав.

Цахилгаан хэмжлийн төрлөөр: Айл өрх, аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй 1 ба 3 фазын 60 цахилгааныг тоолуурыг шалган баталгаажууллаа.

### **Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:**

Өнгөрсөн сард 689 баримтаар 7,593,478.7 мянган төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэлээ.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн цахим хуудас, шилэн данс болон ил тод самбарт байршуулж, аймгийн төсвийн гүйцэтгэлийн 03 дугаар сарын нэгдсэн мэдээг гаргаж Статистикийн хэлтэст хүргүүлж, 03 дугаар сарын аймгийн орлогыг татварын хэлтэстэй тулган баталгаажуулж мэдээг авч хамтарч ажилласан.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг тус тус тавьсан.

Өнгөрсөн сард 724 баримтаар 7,985,307.2 мянган төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэлээ.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн цахим хуудас, шилэн данс болон ил тод самбарт байршуулж, аймгийн төсвийн гүйцэтгэлийн 03 дугаар сарын нэгдсэн мэдээг гаргаж Статистикийн хэлтэст хүргүүлж, 03 дугаар сарын аймгийн орлогыг татварын хэлтэстэй тулган баталгаажуулж мэдээг авч хамтарч ажилласан.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг тус тус тавьсан.

#### **1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:**

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
-----	-------------	------------	-----------	------

<b>1. Орон нутгийн төсвийн нийт орлого</b>		<b>29,101,294.3</b>	<b>27,902,997.1</b>	<b>95.9</b>
1.1	<b>Орон нутгийн төсвийн орлого</b>	<b>6,580,673.1</b>	<b>8,512,088.5</b>	<b>129.3</b>
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	4,582,559.5	4,282,023.1	93.4
	Сумдын төсвийн орлого	1,998,113.6	4,230,065.4	211.7
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	1,211,585.7	1,211,585.7	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	13,733,223.8	13,733,223.8	100.0
1.4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	164,089.2	77,441.4	47.2
1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	687,133.1	397,349.5	-
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	3,537,259.9	3,537,259.9	100.0
1.7	Төсөвт байгууллагын өөрийн орлого	687,575.3	98,642.6	14.3
1.8	ОНХС-д хандив	1,253,333.4		-
1.8	Сум хөгжүүлэх сан /орлого/	1,246,420.8	335,405.7	26.9
<b>2. Орон нутгийн төсвийн нийт зарлага</b>		<b>19,101,294.3</b>	<b>20,688,296.5</b>	<b>71.1</b>
2.1	<b>Орон нутгийн төсвийн нийт зарлага</b>	<b>19,101,294.3</b>	<b>20,688,296.5</b>	<b>71.1</b>
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	7,102,372.3	3,726,624.5	52.5
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	737,575.3	47,316.8	6.4
	Сумдын сум хөгжүүлэх сан			
	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	4,788,692.4	2,344,208.9	49.0
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	208,375.0		
	Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалт			
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	1,778,980.4	259,175.6	14.6
	Халамжийн сан	28,800.0	12,000.0	41.7
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	<b>1,942,537.0</b>	<b>1,608,579.5</b>	<b>82.8</b>
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	830,000.0	464,453.8	56.0
	Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	16,177,602.6	14,337,377.8	88.6
	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	295,051.7	232,768.6	78.9
	<b>3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг</b>		<b>17,725,748.6</b>	<b>17,303,186.5</b>
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	3,305,391.7	3,172,613.2	96.0
3.2	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	35,335.5	35,335.5	100.0
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	35,335.5	35,335.5	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд			
	Хөрөнгө оруулалтын зардалд			
3.3	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	651,797.6	362,014.0	55.5
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	575,647.0	285,863.4	49.7
	Усны татаас	21,650.6	21,650.6	100.0



	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	54,500.0	54,500.0	100.0
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	13,469,082.3	13,469,082.3	100.0
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	264,141.5	264,141.5	100.0
3.6	Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/	13,733,223.8	13,733,223.8	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	7,033,774.5	7,033,774.5	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	4,064,415.9	4,064,415.9	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	2,332,213.2	2,332,213.2	100.0
	- Газрын кадастрын байгууллага	159,402.6	159,402.6	100.0
	- Хүүхдийн байгууллага	143,417.6	143,417.6	100.0
<b>4. Тусгай сангуудын зарлага</b>		<b>1,246,420.8</b>	<b>335,405.7</b>	<b>26.9</b>
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	<b>1,246,420.8</b>	335,405.7	26.9

## 2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2020 03- сар	2021 03- сар	2021-03 2020-03 Х/төгрөгөөр/
<b>1.ХҮНСНИЙ БАРАА</b>				
<b>1</b>	<b>ТАЛХ, ГУРИЛ, БУДАА</b>			
	Гурил /савласан, кг/	1 200	1 300	108.3
	Талх /орон нутгийн, ш/	1 200	1 300	108.3
	Нарийн боов /кг/	2 500	2 500	100.0
	Будаа /кг/	2 500	2 500	100.0
	Элсэн чихэр /кг/	2 200	2 500	113.6
<b>2</b>	<b>МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН</b>			
	Хонины мах /кг/	8 500	8 500	100.0
	Үхрийн мах /кг/	9 500	10 000	105.3
	Адууны мах /кг/	7500	8 000	106.7
	Ямааны мах /кг/	7500	7 500	100.0
	Дотор мах, цувдай /цусгүй/	4000	5 000	125.0
	Хиам /чанасан, кг/	11 000	11 000	100.0
<b>3</b>	<b>СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ</b>			
	Сүү /задгай, л/	1 800	1 900	105.6
	Сүү / савласан, л/	3 000	3000	100.0
	Тараг /задгай, л/	2 000	2 100	105.0
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	16 000	16 500	103.1
	Айраг /л/	4 000	5 000	125.0
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	4 500	100.0
	Өндөг /ш/	350	530	151.4
<b>4</b>	<b>БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС</b>			
	Ургамлын тос /л/	4 200	6 300	150.0
	Өөхөн тос /кг/	2 000	2 500	125.0
	Шар тос /кг/	15 000	15 000	100.0
	Масло /задгай, кг/	4 500	4 500	100.0
<b>5</b>	<b>ХҮНСНИЙ НОГОО</b>			
	Төмс /кг/	1 000	1 200	120.0
	Лууван /кг/	1200	1 500	125.0

	Манжин /кг/	1500	1750	116.7
	Байцаа /кг/	1200	1500	125.0
	Сонгино /кг/	1800	3000	166.7
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	4 200	4 500	107.1
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	3000	3 000	100.0
<b>7</b>	<b>ШАТАХУУН</b>			
	Бензин А - 80	1 680	1 400	83.3
	Бензин А - 92	1 780	1 470	82.6
	Дизелийн түлш	2 470	2 090	84.6

### **Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:**

Аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналтын пост байгуулж ажиллуулах тухай” захирамжаар хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор Ерөө сумын 2 дугаар баг “Өлөнтийн ам” Ерөө сумын бугант тосгоны “Улаангүүр” орчимд 24 цагаар ажиллах хяналтын постыг ажиллуулахаар Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албатай хамтран 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 07 дугаар сарын 20-ны өдрийг дуустал хугацаанд хяналт тавих ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг гарган ажиллалаа.

“Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх” үндэсний хөтөлбөрийн хүрээнд цахимаар иргэд болон төрийн албан хаагчдад “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Ойн тухай хууль, Малын тоо, толгойн тухай хууль, Мал эмнэлгийн эрүүл ахуйн тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиудаар сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулж нийт давхардсан тоогоор 697 гаруй иргэд төрийн албан хаагчдыг хамруулан, АЗДТГ гэсэн фэйсбүүк, цахим хуудсаар дамжуулан 11 төрлийн хууль тогтоомжийг сурталчлан ажиллалаа.

Цагдаагийн газар: Аймгийн хэмжээнд 2021 оны 04 сард 108 холбогдогчтой 331.3 сая төгрөгийн хохиролтой 169 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 37 хэргээр буюу 16.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн илрүүлэлт 32.4 хувьтай байгаа нь өмнө оныхоос 7.3 хувиар буурсан байна.

Улсын бүртгэлийн хэлтсээс 04 дүгээр сард газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ 197, лавлагаа 1 олгож үйлчиллээ.

2 дугаар сард иргэний бүртгэлийн талаар:

- Төрсний бүртгэл -141 /эрэгтэй-73, эмэгтэй-68/
- Гэрлэлтийн бүртгэл -23
- Гэрлэлт цуцалсны бүртгэл -8
- Үрчлэлт - 1
- Эцэг тогтоолт -7
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл -5
- Нас баралт -59
- Нийт олгосон иргэний үнэмлэх -381
- Шинээр олгосон иргэний үнэмлэх -98
- Дахин олгосон иргэний үнэмлэх -94
- Иргэний үнэмлэхийн хугацаа дуусч солиулсан -189
- Гадаад паспорт олголт -46
- Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн -640
- Хот доторх шилжилт хөдөлгөөн - 1156 тус тус бүртгэгдсэн байна.

Төрийн архивын 2021 оны бүрдүүлэлтийн төлөвлөгөөний дагуу аймгийн Биеийн тамир, спортын газар, Стандарт, хэмжил зүйн хэлтэст бүрдүүлэлт хийх тухай албан бичгүүдийг хүргүүлэн Биеийн тамир, спортын газрын архив, бичиг хэргийн эрхлэгчид төрийн архивд баримт шилжүүлэх ажиллагааны талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Ардын хувьсгалын 100, аймаг байгуулагдсаны 90 жилийн ойг угтан Сэлэнгэ аймгийн түүхэнд холбогдох баримтуудыг олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд аймгийн МАН-ын хорооны хөмрөг дэх 1938-1942 онд холбогдох Цагаан эрэг хотыг Сүхбаатар хот болгон өөрчлөн нэрлэх тухай, Лам нарын нэгтгэл байгуулсан тухай, ардын сайн дурын сургуулиуд байгуулах тухай, сумдын дарга нар ба анхны хоршоод зэрэг байгууллагуудын дарга нарыг томилсон баримтуудыг хөрвүүлэн бэлтгэж аймгийн албан ёсны цахим хуудсанд байршуулсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны А/38 дугаар тушаалын дагуу хийгдэж байгаа нэгдсэн тооллогыг эхлүүлсэн бөгөөд тайлангийн хугацаанд 78 хөмрөгийн 7016 баримтыг тоолж тэдгээрт тооллогын акт, хуудас хөтөлсөн. Тооллогын ажил үргэлжлэн хийгдэж байгаа болно.

Баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд “Сэлэнгийн долгио” чуулга, Баруунхараа дахь зам засвар, арчлалтын “Хараа” компанийн хөмрөгийн нийт 14 ХН-ийн 1576 хуудас баримтын агуулгыг уншиж заалт 1382, хүний нэр 5259, газарзүй нэр 209, байгууллагын нэр 173 шивж эх баримттай холбох ажлыг хийж гүйцэтгэлээ. Иргэд, албан байгууллагын хүсэлтийн дагуу архивын хуулбар 191, архивын тодорхойлолт, магадалгаа 19, малын А дансны лавлагаа 2 тус тус гаргаж ажиллалаа.

#### **Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:**

##### **1. Боловсрол, соёл урлаг, спортын талаар:**

Шинэ төрлийн коронавирусийн халдвар /Ковид-19/-ын цар тахлын улмаас хичээл, сургалтын үйл ажиллагаа 2 дахь хичээлийн жилдээ танхимын бус хэлбэрээр зохион байгуулагдаж байгаа бөгөөд сурагчдын 3 дугаар улирлын цахимаар үзсэн хичээл, сургалтын үнэлгээг 3 долоо хоногээр нэгтгэн гаргахад өмнөх түвшнөөс 0.3-1.8% ахисан үзүүлэлттэй байна.

Улсын Их хурлын гишүүн Ч.Ундрамын санаачилгаар 2020-2021 оны хичээлийн жилд төгсөх ангийн сурагчдад зориулан элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст оноог ахиулах, хүссэн мэргэжлээ сонгох, цаашид амжилттай суралцах боломжийг бүрдүүлэх зорилгоор цахим сургалтыг зохион байгуулж байна. Цахим сургалтад 12 дугаар ангийн 1081 сурагч бүртгүүлсэн бөгөөд Улсын Их хурлын гишүүн Ч.Ундрамын ажлын албанаас 7 хоног бүр суралцагчдын ирц, идэвх оролцооны мэдээлэлд анализ хийж ажиллаж байна. Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1, 2, 3, 6 дугаар сургуулиуд, Мандал сумын ерөнхий боловсролын 1, 2 дугаар, Хэрх, Түнхэл, Рашаант, Дулаанхаан тосгодын ерөнхий боловсролын сургуулиудын ирц, идэвх оролцоо маш сайн байна.

2022 оны улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийх төсөл арга хэмжээний санал боловсруулахтай холбоотой төсөлд тусгах саналын “Санхүү, эдийн засгийн шинжилгээ, судалгаа”-ны талаар аймгийн хэмжээнд боловсролын салбарын нягтлан бодогч нарт цахим сургалт зохион байгуулсан.

Элсэлтийн ерөнхий шалгалтын хичээлүүдээр авсан цахим шалгалтад ерөнхий боловсролын 33 сургуулийн /Сант сумын ерөнхий боловсролын сургуулиас бусад /12-р ангийн 837 сурагч давхардсан тоогоор 2115 шалгалт өгч, тэдний даалгаврын гүйцэтгэл, авсан оноог судлагдахуун бүрээр гарган сургуулиудад хүргүүлээ.

Боловсрол Шинжлэх Ухааны яамнаас /Ковид-19/-ын халдварын нөхцөл байдалтай холбогдуулан зөвхөн ОУ-ын хэмжээнд оролцох багийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах чиглэл, хуваарийн дагуу онлайн олимпиадад сурагчдаа оролцуулж 2-р шатанд аймгийн хэмжээнд ахлах ангийн нийт 18 сурагч тэнцсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах журмын төслийг төрийн болон төрийн бус өмчийн 40 цэцэрлэгээр хэлэлцүүлэн саналыг нэгтгэн Боловсрол Шинжлэх Ухааны яаманд хүргүүлсэн.

Хүүхдийг багаас нь Тогтвортой хөгжлийн боловсролын мэдлэг чадвар, арга хандлага эзэмших, тогтвортой амьдралын хэв маяг, зан үйлд хөтлөх хувирган өөрчлөх арга зүйд суралцсан арга зүйн шинэлэг санаа, шийдэл бүхий хичээлийг түншлэгч талуудтай хамтран бүтээх сургалтын менежментийг хөгжүүлж, багшлахуйн сайн туршлагыг илрүүлэн, түгээн дэлгэрүүлэх зорилгоор улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй “ДЭЛХИЙН ТОМ ХИЧЭЭЛ-ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ” -ын хүрээнд аймгийн хэмжээнд бүх цэцэрлэгүүдээр хичээл бэлтгүүлэн, 70 хувиас дээш үнэлгээ авсан 10 хичээлийг Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн онлайн талбарт байршууллаа.

“Улсын хэмжээний англи хэлний марафон “Элсэлтийн ерөнхий шалгалт 2021” уралдаанд аймгийн 10-12-р ангийн сурагчдын англи хэлний түвшинг дээшлүүлэх, элсэлтийн ерөнхий шалгалтад өндөр оноо авахад нь дэмжих зорилгоор энэхүү хөтөлбөрт нийт 167 сурагч оролцсон. Тус хөтөлбөрт нийт 904 сурагч оролцсоноос Лаборатори 4 дүгээр сургуулийн 126 ангийн сурагч Б.Аминаа 2439932 үг уншиж тэргүүн байр, 116 ангийн сурагч Э.Болор 5 дугаар байр эзэлсэн. Сурагчдаа амжилттай оролцуулсан шилдэг багшид Сайхан 2 дугаар сургуулийн багш Л.Энхцэцэг 4-р байранд, Лаборатори 4 дүгээр сургуулийн багш Б.Сүхмаа 5-р байр эзэлж амжилт гаргасан.

Соёлын яамнаас уриалсан “Цахим орчинд соёл түгээе би хариуцлагатай иргэн” уриан дор музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа гэрэл зургуудаас “Ардын хувьсгалын анхны долоон төлөөлөгч, ардын хувьсгалын партизануудын гэрэл зураг” бүхий мэдээллийн 2 багц 11 ширхэг үзмэрийг цахим орчноор дамжуулан сурталчлан танилцуулсан бөгөөд “Монгол зан үйл, ёс заншил”, “Уламжлалт цагаан идээ”, “Байгалийн үзэгдэл”, “Шувуу” зэрэг 4 багц 120 ширхэг зурагт мэдээллийг цахим орчинд түгээн мэдээлэл хүргэж ажилласан.

Олон Улсын музейн өдрийг угтан музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа Ардын хувьсгалын удирдагч Д.Сүхбаатар жанжны эдэлж, хэрэглэж байсан эд зүйлсээр видео контент хийж цахим орчинд түгээн дэлгэрүүллээ.

Музейн боловсролын ажлаар дамжуулан “Шагайгаар наадацгаая” уралдааныг цахим орчинд түгээн дэлгэрүүлэх, сурталчлах үйл ажиллагааг эхлүүлсэн ба уг уралдаанаар Шаамар сумын ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар ангийн сурагч М.Мичидмаа, 4 дүгээр ангийн сурагч Т.Намуун, Алтанбулаг сумын 3 дугаар ангийн сурагч А.Отгонням, 2 дугаар ангийн сурагч О.Лхагва-Эрдэнэ, М.Амин-Эрдэнэ нар идэвхтэй оролцож шагналт байранд шалгарсан.

“Эрүүл мэндийн цахим гүйлт-2021” биеийн тамирын арга хэмжээ Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Биеийн тамир спортын Улсын хорооноос Монгол орон даяар зохион байгуулсан биеийн тамирын арга хэмжээнд нийт дүнгээр 21 аймгаас 68,597 хүн 635,641 км зам туулснаас манай аймаг 300 гаруй иргэн хамрагдаж нийт 4000 гаруй км замыг туулж амжилттай оролцсон.

“Дасгалаа хийж дархлаагаа дэмжье” челленжийг 17 сум 6 тосгоны ахмадуудын дунд зохион байгуулж, нийт 63 ахмадууд хамрагдан бие бялдраа чийрэгжүүлэн, дархлаагаа дэмжин оролцсон.

## **2. Эрүүл мэндийн талаар:**

**Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг дархлаажуулалтыг зохион байгуулах чиглэлээр:** Эрүүл мэндийн сайдын 2021 оны “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулах үйл ажиллагааг зохион байгуулах тухай” тушаалын дагуу “Халдварт өвчин судлалын үндэсний төв”-ийн дархлаажуулалтын албанаас 04 дүгээр сарын 03-ны өдөр 15000 хүн тун коронавирүсийн эсрэг “Вероцелл вакцин”-ыг татан авч, бүх дархлаажуулалтын нэгжүүддээ хуваарилан хүргүүлсэн.

Аймгийн хэмжээнд 04 дүгээр сарын 04-08-ны өдөр дархлаажуулалтын үйл ажиллагааг зохион байгуулж, зорилтот бүлгийн 14733 хүнийг Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины I тунд хамруулаад байна.

Баруунбүрэн суманд Коронавирүсийн халдвар дэгдэлт байдлаар тархсантай холбогдуулан аймгийн Онцгой комиссын шийдвэрээр тус сумын иргэн бүрийг түргэвчилсэн шинжилгээнд хамруулахаар аймгийн Засаг дарга бөгөөд, Онцгой комиссын дарга Ш.Оргил, Эрүүл мэндийн газрын дарга Ж.Од нараар ахлуулсан 36 хүний бүрэлдэхүүнтэй оношлогооны 10, халдваргүйтгэлийн 1, татан авалтын 1 нийт 12 баг томилогдон ажилласан. Сумын төвд 814 шинжилгээ, хөдөөд 346 нийт 1160 иргэнийг түргэвчилсэн шинжилгээнд хамруулж, үүнээс 10 хүний тест эерэг гарч тухайн иргэдээс баталгаажуулах ПСР-н шинжилгээ авч сорьцыг аймгийн Нэгдсэн эмнэлгийн “Вируслогийн лаборатори”-д тээвэрлэн хүргэсэн. Зоонозын өвчин судлалын төвийн мэргэжилтнүүд голомтын, цэгүүдийн болон талбайн халдваргүйтгэлийг тус тус хийсэн. 03 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн аймгийн Нэгдсэн эмнэлэгт Коронавирүсын халдварыг эмчлэх тасгийг нээн нийт 134 батлагдсан тохиолдлыг хэвтүүлэн эмчилсэн бөгөөд өнөөдрийн байдлаар нийт 98 хүн эдгэрэн эмнэлгээс гарсан байна.

Тус тасагт нийт 6 их эмч, 18 эмнэлгийн ажилчид ажиллаж байгаа ба Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны А/20 тоот тушаалаар байгуулагдсан Эмнэлзүйн зөвлөх баг өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна.

## **3. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын хүрээнд:**

Халамжийн санд улсын төсвөөс тайлант хугацаанд 33424 иргэнд 5023142.4 мянган төгрөгийг олгоод байна. Үүнд:

1. Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2350 иргэнд 992818.9 мянган төгрөг
2. Нийгмийн халамжийн тэтгэмжид 1685 иргэнд 580522.2 мянган төгрөг
3. Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжид 1637 иргэнд 394982.6 мянган төгрөг
4. Жирэмсэн эхийн тэтгэмжид 1086 эхэд 116138.3 мянган төгрөг
5. 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж 5079 эхэд 963120.4 мянган төгрөг
6. Ихэр хүүхдийн тэтгэмжид 7 иргэнд 14000.0 мянган төгрөг
7. Эхийн алдар одонгийн тэтгэмжид 8847 иргэнд 1140200.0 мянган төгрөг
8. Насны хишиг тэтгэмжид 5023 иргэнд 395350.0 мянган төгрөг
9. Өрх толгойлсоны тэтгэмж 251 иргэнд 96675.8 мянган төгрөг
10. Ахмадын настанд олгох хөнгөлөлт, тусламжид 1798 ахмадын 50375.0 мянган төгрөг

11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламжид 234 иргэний 35327.0 мянган төгрөг

12. Хүнсний эрхийн бичгийн 5427 иргэнд 243631.9 мянган төгрөгийг тус тус зарцууллаа.

Халамжийн санд орон нутгийн төсвөөс тайлант хугацаанд 12 иргэнд 14400.0 мянган төгрөгийг олгоод байна. Үүнд:

1. Орон гэрийн хөнгөлөлт, тусламжид 12 иргэнд 14400.0 мянган төгрөгийг зарцууллаа.

Орлогын талаар: 251000.0 мянган төгрөгийн санхүүжилт орж ирсэн. Мөн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт 102 иргэний 132375.7 мянган төгрөг орж ирсэн байна.

Авлагын талаар:

№	Хөтөлбөрийн нэр	2021 оны эхний үлдэгдэл	Энэ онд шинээр нэмэгдсэн	Эргэн төлөлт хийсэн дүн	Эцсийн үлдэгдэл
1	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	356,168,385		45,744,325	310,424,060
2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	63,972,960		13,366,000	50,606,960
3	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	399,318,610		57,214,350	342,104,260
4	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	27,788,500		6,025,000	21,763,500
5	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	152,463,075		10,026,000	142,437,075
6	<b>Нийт дүн</b>	<b>999,711,530</b>		<b>132,375,675</b>	<b>867,335,855</b>

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв санлуу санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт болох 91653.4 мянган төгрөг төвлөрүүлэн ажиллаж байна.

#### **4. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:**

17 сум 6 тосгодын нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй цахим уулзалт зохион байгуулж, цаг үеийн холбогдолтой мэдээ мэдээллийг солилцон цаашид хүүхдийн эрх аюулгүй байдлыг хангах талаар 6 чиглэл зөвлөмжийг өгч мэргэжлийн удирдлагаар хангаж ажилласан.

“Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв”-өөс хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой 17 дуудлага мэдээлэл бүртгэгдсэн. Үүнд: хүүхэд хамгааллын дуудлага 2, хүүхдийн эрхийн зөрчлийн дуудлага 2, зөвлөгөө, мэдээлэл хүссэн дуудлага 12, зорилтот бус дуудлага 1 ирсэн.

“Залуучуудын хөгжлийн төв”-өөр дамжуулан “Суралц, хуримтлуул, өсгө” уриатай 8-12 дугаар ангийн сурагчдад, гэр бүлийн болон хувь хүний санхүүгийн боловсрол олгох аяныг цахимаар зохион байгуулж, нийт 138 хүүхэд, залуучуудыг хамруулан, 5088 хандалтыг авч ажилласан.

Үүнд:

- “Мөнгө гэж юу вэ?”, /хамрагдсан залуучууд 39, хандалт 1000/
- “Хуримтлал гэж юу вэ?”, /хамрагдсан залуучууд 22, хандалт 772/
- “Өрхийн төсөв гэж юу вэ?”, /хамрагдсан залуучууд 27, хандалт 1000/

- “Зээл ба Зээлийн хүү”, /хамрагдсан залуучууд 33, хандалт 2000/
- “Санхүүгийн эрсдэл түүнээс урьдчилан сэргийлэх” /хамрагдсан залуучууд 17, хандалт 316/

### **Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд:**

#### **1. Мал эмнэлгийн үйлчилгээний талаар:**

Мал, амьтны халдварт өвчний мэдээний хувьд Алтанбулаг, Ерөө, Зүүнбүрэн, Орхонтуул зэрэг сумдад халдварт Шөвөг яр бог төл өвчилсөн 100, үхсэн 6, эдгэрсэн 94 Цахлай өвчнөөр тугал өвчилсөн 27, эдгэрсэн 27, нийт өвчилсөн 127, үхсэн 6, эдгэрсэн 121 мал, амьтан тус тус өвчилж эдгэрсэн.

Халдваргүй өвчнөөр нийт 458 толгой мал өвчилсөн ба үүнээс Тэжээл боловсруулах эрхтний эмгэг 60 буюу 13,1 хувь, амьсгалын замын эрхтний эмгэг 116 буюу 25,3 хувь, зүрх, судас мэдрэлийн системийн эмгэг 97 буюу 21,2 хувь, шээс бэлэг, үржлийн эрхтний эмгэг 85 буюу 18,5 хувь, бодис солилцооны эмгэг 8 буюу 1,7 хувь, эндемик өвчин 19 буюу 4,1 хувь, элдэв хордлого 60 буюу 13,1 хувь, гэмтэл, бэртэл 13 буюу 2,8 хувийг тус тус эзэлж байна. Халдваргүй өвчнөөр хорогдсон малын тоо 28 толгой буюу нийт өвчилсөн малын 6,1 хувийг эзэлж байгаа бол 430 толгой мал буюу 93,8 хувь нь МЭҮН-ийн авч хэрэгжүүлсэн эмчилгээний үр дүнд эдгэрсэн үзүүлэлттэй байна.

Шөвөгч яр, сахуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад 86000 тол мал хамруулсан. Мал сүргийн эрүүл мэндийн үзлэгийг энэ сард 86000 толгой малд үзлийг хийж ажилласан.

Хүнсэнд нийт 1859 гэрчилгээгээр адуу 134, үхэр 667, хонь 2053, ямаа 874, тэмээ 10, гахай 19, нийт 3756 толгой мал, амьтан худалдаалсан бол махан бүтээгдэхүүн 125640 кг мах , 664885 л сүү сүүн бүтээгдэхүүн, арьс шир, түүхий эд 15942 кг бүгд 806467 кг малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд баталгаажуулалт хийж, нийт 2157 гэрчилгээгээр адуу 780, үхэр 1051, хонь 2374, ямаа 1727, тэмээ 10, гахай 28, нийт 5970 толгой мал, 125640 кг мах махан бүтээгдэхүүн, 664885 кг сүү сүүн бүтээгдэхүүн, түүхий эд 15942 кг нийт 806467кг бүтээгдэхүүн, мал амьтанд мал эмнэлгийн гэрчилгээг баталгаажуулан олгож ажиллалаа.

Ариутгал халдваргүйтгэлд малын хашаа хороо 91 ширхэг 11509 м2, гахайн байр 7 ширхэг 2704 м2, шувууны байр 8 ширхэг 86 м2, тээврийн хэрэгсэл 1 ширхэг 20 м2, зоорь 3 ширхэг 68 м2, тэжээлийн агуулах 7 ширхэг 208 м2, худаг уст цэг 6 ширхэг 260 м2, хэвтэр бууц 5 ширхэг 176 м2, бэлчээр 120 м2, устгалын цэг 1000 м2, сэг зэм 11 ширхэг 3230 м2, нийтийн эзэмшлийн талбай 3050 м2 **нийт 22431 м2** талбайд ариутгал халдваргүйтгэл хийж ажилласан.

#### **2. Хөдөө аж ахуйн талаар:**

2021 оны хаврын тариалалтын бэлтгэлийг хангахад чиглэсэн олон ажил арга хэмжээг төлөвлөн онцгой дэглэм мөрдөн ажиллаж байгаа энэ цаг үед бид улаанбуудай, төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч засгийн газраас хөнгөлөлттэй зээл, төмс, хүнсний ногооны үр, техник тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис, шатахууныг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгохоор ажиллаж байгаа тул сумдын Засаг дарга нар нийт тариалах талбайн 80 доошгүй хувьд улаанбуудай тариалах гэрээ хийх, орон нутагтаа “Өрхийн тариалан” хөдөлгөөн өрнүүлэх замаар 2021 оны тариалалтын төлөвлөгөөг давуулан тариалах чиглэл хүргэн ажиллаж байна.

2021 онд аймгийн хэмжээнд 284 аж ахуйн нэгж, 154 иргэн нийт 193,3 мянга талбайд тариалалт хийхээр төлөвлөснөөс 157,2 мянган га талбайд улаанбуудай, 5990 га талбайд бусад үр тариа, 8,6 мянган га талбайд тэжээл, 17 мянган га талбайд тосны

ургамал, 2722 га талбайд төмс, 2789 га талбайд хүнсний ногоо тариалахаар төлөвлөөд байна.

Хаврын тариалалтын улаанбуудайн үрийн хэрэгцээнд 23874 тн үр шаардагдахаас аж ахуйн нэгжийн өөрсдийн нөөцөлсөн үр 17148 тн, дутагдах 9858 тн үрийн захиалгыг иргэн аж ахуйн нэгжээс авч Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд санал хүргүүлсэн. Мөн хүнсний ногооны үйлдвэрлэлээр дотоодын хэрэгцээг хангах зорилтын хүрээнд “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас “Өрхийн тариалан хөдөлгөөн” өрнүүлэн ногоочдыг үрээр хангах зорилгоо хүнсний ногооны үрийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох ажлын хүрээнд аймгийн 17 сумын 1050 иргэнээс 11 нэр төрлийн 94,3 тн хүнсний ногооны үрийн захиалга авч Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.

Улсын хэмжээнд зохион байгуулсан вакцинжуулалтад Улаанбаатар хотоос Сэлэнгэ аймагт ирэх 231 тариаланч, ногоочид, аймаг орон нутгаас ажиллах 3602 тариаланч ногоочдыг вакцинжуулалтад хамруулах ажлыг аймгийн аймгийн хэмжээнд зохион байгуулан 920 тариаланч, 1600 ногоочин нийт 2751 тариаланч ногоочин вакцины нэгдүгээр тунд хамрагдсан.

Хаврын тариалалтын бэлтгэл ажил эхэлсэнтэй холбогдуулан Улаанбаатар хот болон Дархан-Уул аймаг, бусад аймаг орон нутгаас 04 дүгээр сарын 13-ны өдрийн байдлаар 12 сумын 55 аж ахуйн нэгжид нийт 361 тариаланч ногоочид ирснээс 130 нь тусгаарлалтад байна.

17 сумын 204 иргэн, аж ахуйн нэгж 55150 мянган га талбайд оготно устгах ажил, 30.0 гаруй га талбайд тариалалтын өмнөх боловсруулалт хийж байна.

Аймгийн хэмжээнд том малын зүй бус хорогдол нийт 3237 мал хорогдсоноос адуу 170, үхэр 408, хонь 1641, ямаа 1018 үүнээс хээлтүүлэгч мал 18 хорогдсон байна. 04 дүгээр сарын байдлаар 711252 хээлтэгч мал төллөхөөс 570815 мал төллөж, үүнээс ингэ 63, гүү 9842, үнээ 44691, эм хонь 282179, эм ямаа 234040 төллөж, мал төллөлтийн хувь 78,5 хувьтай байна. Бог мал 80 хувьтай, бод мал 47 хувьтай төллөсөн байна. Төл малын хорогдол 1537 байна. Аймгийн хэмжээнд хаваржилт, мал төллөлт хэвийн явагдаж байна.

Сайхан, Орхон, Сант, Орхонтуул, Баруунбүрэн, Мандал, Баянгол, Ерөө, Жавхлант, Хушаат сумдад Өвөрхангай, Төв, Хэнтий, Дундговь, Булган, Архангай, Орхон, Дархан-Уул, Баянхонгор, Булган, Хэнтий аймгуудаас нийт 106 өрхийн 64041 мян.тол мал отор нүүдлээр ирж өвөлжиж хаваржсан.

Отроор хаваржиж буй малчдад эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээг үзүүлж, коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэн хяналт тавих, оторчдын буцах маршрут тогтоож, зураглал гаргаж 04 дүгээр сарын 01-ний өдрөөс орон нутагт нь буцаах талаар мэдэгдэл өгч 04 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар 47 өрхийн 44828 толгой мал өөрийн аймаг, сум руу буцсан байна. Үлдсэн отроор ирсэн малчдыг 04 дүгээр сарын 25-аас хөл хорио тавигдсаны дараа буцаахаар ажиллаж байна.

“Эрүүл мэндээ хамгаалж-Эдийн засгаа сэргээх” 10 их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд “Ажлын байр дэмжих зээл”-нд хамрагдахаар нийт өссөн дүнгээр арилжааны банкнуудад 1200 аж ахуйн нэгж, иргэдээс 119.2 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлт ирснээс 461 аж ахуйн нэгж, иргэдэд 27,7 тэрбум төгрөгийн 3 хувийн хүүтэй зээл олгогдсон. Мөн 31 аж ахуйн нэгж, иргэд 1,3 тэрбум төгрөгийн өндөр хүүтэй зээлээ хүү багатай зээл рүү шилжүүлсэн байна. Өнгөрсөн долоо хоногт 15 ахуйн нэгж иргэдээс 426,0 сая төгрөгийн хүсэлт ирүүлснээс 22 аж ахуйн нэгж иргэдэд 799.8 сая төгрөгийн зээл олгосон байна. Аймгийн хэмжээнд бүх сумдын арилжааны банкнуудад аж ахуйн



нэгж, иргэд зээлийн хүсэлт ирүүлээд байна. Ажлын байр дэмжих хөнгөлөлттэй зээл одоогийн байдлаар Түшиг сумын аж ахуйн нэгж иргэдэд олгогдоогүй байна.

## 2. Байгаль орчны талаар:

Ойн зурвасын ажил гүйцэтгэхээр “Агрофорест” ХХК шалгаран Алтанбулаг, Жавхлант суманд тус бүр 10 га талбайд ойн зурвас байгуулахаар боллоо

Алтанбулаг суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын 2020 оны мод бэлтгэлийн гүйцэтгэлийг мод бэлтгэсэн талбай, дээд, доод агуулах, мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ, ойгоос мод бэлтгэхээр тусгаарласан талбайд аймгийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран шалгалт хийж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Хуш модны самрын хууль бус бэлтгэлийг таслан зогсоох тухай” А/103 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Хилийн 0243 дугаар анги, аймгийн Тагнуулын газар, Онцгой Байдлын газар, Цагдаагийн газар, Хүдэр, Ерөө, Мандал сумдын ЗДТГ, сумын болон сум дундын Ойн анги, Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын Захиргааны ажилтнуудтай хамтарсан ажлын хэсэг Хүдэр, Ерөө, Мандал сумдын нутагт /ууланд/ самар түүж буй иргэдийг албадан буулгах арга хэмжээг 04 дүгээр сарын 09-15-ны хооронд зохион байгуулсан. Хууль хяналтын байгууллагуудын хамтарсан хяналт шалгалт хийх албадан буулгах 6 бүлэг Хүдэр, Ерөө, Мандал сумдад ажиллаж нийт 54 отгийн 30 автомашинтай 400 гаруй иргэдийг буулгасан.

Хаврын “Бүх нийтээр мод тарих өдөр”-ийн хүрээнд Сүхбаатар самбараас 5 дугаар багийн Дашваанжил клонк хүртэл нийт 4.6 км буюу 4600 метр талбайд мод тарих талбайг сонгож, ОУ-ын автозам дагуу зүүн талдаа нарс модыг 1 эгнээгээр 3 метрийн өргөнтэй 4600 метр талбайд мод хоорондоо 4 метрийн зайтай 1150 ширхэг мод тарьж 9300 метр талбайд хашаа хийх тооцооллыг гаргаж ажиллалаа. Мөн тус ажлын хүрээнд “Нэг өрх-Нэг шинэ мод” уриатай сурталчилгааг шторк хэлбэрээр телевиз, өдөр тутмын сониноор сурталчлах ажлуудыг хийж байна.

2021 онд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх ургамлын саналыг сумдаас авч нэгтгэж байна. Одоогийн байдлаар “Их тайга” ХХК /цайны үйлдвэр/ хусны навч 2 тн, “Монос фарм” эмийн үйлдвэр Далан түрүү 0,5 тн, Таван салаа 0,5 тн, Долоогоно 0,05 тн, Нохойн хошуу 0,05 тн, Цахилдаг 0,06 тн, Хүдэр амжаа ХХК халиар сонгино 10 тн түүж бэлтгэх санал ирүүлээд байна.

## 3. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын талаар:

№	Аймгийн Засаг даргын захирамжийн утга	Өргөдлийн тоо		Захирамжаар олгосон газрын хэмжээ /м <sup>2</sup> /		Бүгд газрын хэмжээ /м <sup>2</sup> /
		Иргэн	ААНБ	Иргэн	ААНБ	
1	Газар эзэмших эрх баталгаажуулах	7	1	0.42	0.2	0.62
2	Газар эзэмших эрх шилжүүлэх тухай	20		0.82		0.82
3	Газар эзэмших эрх хэсэгчлэн шилжүүлэх	5		0.11		0.11
4	Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах	5	2	0.17	0.49	0.66
5	Эзэмшил газрыг нэгтгэн эзэмшүүлэх	2		0.15		0.15
6	Шинээр газар эзэмшүүлэх	24	2	0.77	3.33	4.1

<b>Нийт</b>	<b>63</b>	<b>5</b>	<b>2.44</b>	<b>4.02</b>	<b>6.46</b>
-------------	-----------	----------	-------------	-------------	-------------

**Зураг төсөл хянасан байдал:**

1. Ерөө сумын төв доторх автозамын засвар шинэчлэлтийн техникийн зураг төсөл
2. Хүдэр суманд бетон хучилттай автозамын засвар шинэчлэлтийн техникийн зураг төсөл
3. Ерөө сум Бугант тосгоны 1,1 км хайрган хучилттай автозамын засвар шинэчлэлтийн техникийн зураг төсөл
4. Зүүнбүрэн суманд хайрган хучилттай автозамын засвар шинэчлэлтийн техникийн зураг төсөл
5. Орхонтуул сумын Хонгор овоо багийн мал угаалгын ванн
6. Ерөө сумын наадмын талбай
7. Мандал сум, Хэрх багийн ерөнхий боловсролын дунд сургуулийн дээврийн засварын зураг.
8. ТЕГ-ын Сэлэнгэ аймаг дахь газрын албан конторын барилга
9. Ерөө сум Тавин, Буурагчин багийн авто зам дагуух гудамжны гэрэлтүүлэг
10. Ерөө сумын гэрэлт гудамжны гэрэлтүүлэг
11. Сант сумын цэвэр усны шугам солих ажил.

**Архитектур төлөвлөлтийн даалгавар гаргаж өгсөн байдал:**

1. Алтанбулаг чөлөөт бүс дэх “Өсөх буудай чөлөөт бүс ХХК”-ий кофе шоп.
2. ТЕГ-ын Сэлэнгэ аймаг дахь газар
3. Мандал сум ахмадын төв
4. Сүхбаатар сум “Дүү Трейд” ХХК-ий орон сууц
5. Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төвийн барилга
6. Алтанбулаг сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгавар
7. Сайхан сумын Хүүхэд залуучуудын хөгжлийн ордны зураг төсөл боловсруулах даалгавар
8. Сайхан суманд хийгдэх автозамын ажлын инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын даалгавар

Барилга, хот байгуулалтын салбарын хууль тогтоомж, төсөл, хөтөлбөр, арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлэх, хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн мэдээллийг бүрдүүлэн ажиллаж байна. Кадастрын мэдээллийн нэгдсэн систем, URBAN MANAGER программд аймгийн хэмжээнд 364 барилга бүртгэгдсэн. Үүнд нөхөн бүрдүүлэлт хийх үүднээс 126 барилгад дутуу мэдээллийг бүрдүүлж барилга байгууламжийн маягт хэвлэхэд бэлэн болгон ажиллалаа.

**Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг**

- Тоглоомын талбайн тохижилтын ажил /Сүхбаатар сум, 1-р баг/
- 200 ортой цэцэрлэгийн барилга /Ерөө сум/
- Халуун усны барилга /Шаамар сум, Дулаанхаан тосгон/
- Өвлийн хүлэмж барих ажил /Ерөө сум 1-р баг/ ажлуудад тус тус олгосон.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Жавхлант суманд “БЗД” ХХК-ий гүйцэтгэж буй “Соёлын төвийн барилга”-ын их засварын ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллалаа.

Хушаат суманд “Густокек” ХХК-ий гүйцэтгэж буй эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажлын гүйцэтгэлд хяналт тавих ажлыг эрчимжүүлэх зорилгоор ажлын хэсэг барилга байгууламжид үзлэг шалгалтыг хийж, ажлын гүйцэтгэл 90 хувьтай үргэлжилж

байна. Ажлын хэсгээс дутуу хийгдсэн ажлыг хурдан хугацаанд хийж гүйцэтгэх, төсвийн зөрүүг гаргаж тухайн зардлаар барилгын дээврийн дулаалгыг хийж гүйцээх, ажлыг 04 дүгээр сарын 15-ны дотор багтаан ашиглалтад хүлээлцүүлэх үүрэг даалгаврыг өгсөн.

#### **4. Орон нутгийн өмчийн талаар:**

Олон жил ашиглагдаж элэгдлээ нөхсөн, цаашид ашиглах боломжгүй ашиглалтгүй байгаа байгууллагуудын үндсэн хөрөнгийг актлах, балансаас балансад шилжүүлэх үндсэн хөрөнгө ашиглалтгүй байгаа тээврийн хэрэгслийг дуудлага худалдаанд оруулах зэрэг албан хүсэлтээр ирсэн бичгийг аймгийн Засаг даргад танилцуулан ИТХ-ын Тэргүүлэгчдийн Хурлаар хэлэлцүүлж ажиллалаа.

Сумдууд болон хэлтэс, агентлагуудын 2021 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn/-д оруулахад хяналт тавьж ажиллаж байна.

2020 онд төсвийн хөрөнгө оруулалтаар Цахилгааны эх үүсвэрийн шугам татах, Дугуйт ачигч ковш худалдан авах, Сумын эмнэлэгт эхо аппарат авах, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ажлын хэрэгцээнд автомашин авах, аймгийн ИТХ-ын төлөөлөгч нарт таблет худалдан авах, эм эмнэлгийн хэрэгсэл, цэцэрлэгийн барилгын өргөтгөл, Баруунбүрэн, Ерөө, Шаамар, Түшиг, Цагааннуур зэрэг сумдад ойн хөнөөлт шавжийн тэмцлийн ажлыг ойн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх зэрэг ажлуудад үнэлгээ хийж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажиллаж байна.

#### **Зургаа. Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:**

##### **Алтанбулаг сум:**

Сумын Засаг даргын 2021 оны “Зэрэглэлд шилжүүлж, эргүүл жижүүр томилох тухай” А/74 тоот захирамжийн дагуу авто замын хяналтын 1 цэг, шуурхай штабын жижүүрт төр төсвийн байгууллагын 64 албан хаагчид үүрэг гүйцэтгэж байна.

Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1.3 дахь зорилтын 1.3.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор сумын Засаг даргын 2021 оны “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-3 ажлын хэсэг байгуулах тухай” А/51 тоот захирамжийн дагуу “**Үндэсний бичгээрээ уншиж бичигцгээе 2021-2025**” аяныг эхлүүлэн анхан шатны сургалтад 32 ажилтан албан хаагч хамрагдсан.

Жил бүрийн 04 дүгээр сард Сэлэнгэ аймгийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлөөс зохион байгуулдаг “Хямралыг урьдчилан харж, бэлтгэлтэйгээр даван туулья-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтолцоог бэхжүүлэе” уриан дор “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян 2021” арга хэмжээ эхэлж, аяны хүрээнд нийт ажил олгогч нарт үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх соёл, зан үйлийг төлөвшүүлэх, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжоор хүлээсэн эрх, үүргээ хэрэгжүүлэх, халдвар хамгааллын дэглэмээ баримтлан ажиллах талаар мэдээ мэдээллийг хүргэж ажилласан.

Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 26 дугаар тушаал “Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний стратеги төлөвлөгөө”-г үндэслэн Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн ажилтан, төр төсвийн байгууллагатай хамтран сумын 759 иргэнийг коронавируст халдвараас сэргийлэх дархлаажуулалтад хамруулж, Улаанбаатар хот болон эрсдэлт бүс аймаг сумаас ирж гэрийн ажиглалтад орсон 85 иргэнээс ПСР, 20 иргэнээс түргэвчилсэн оношлуураар шинжилгээ авч бүгд сөрөг гарсан.

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын тархалт нэмэгдэж байгаатай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны “Хичээл сургалтын үйл ажиллагааг түр зогсоох тухай” А/98 тоот захирамжийн дагуу ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагааг түр хааж зайн хэлбэрт шилжүүлсэнтэй холбогдуулан хүүхэд хамгааллын ажилд онцгой анхаарч “Хүүхэд хамгааллын тухай хууль” болон ахуйн осол, гэмтэл, эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор багш ажилчид өдөр бүр эцэг эхийн дундын Facebook хаягаар болон сумын Altanbulag ZDTG Цахим хаягаар дамжуулан сэрэмжлүүлэг болох шторк, хэвлэмэл материал байршуулан ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургуулийн 799 сурагчаас 703 сурагч цахим хичээлд хамрагдаж хамрагдалт 88 хувьтай, сургуулийн өмнөх боловсролын 230 хүүхдээс 218 хүүхэд теле хичээлд хамрагдаж байна.

#### **Баруунбүрэн сум:**

Хичээл сургалтын үйл ажиллагаа теле болон цахим хэлбэрээр орж байгаатай холбогдуулан 1-12 дугаар ангийн цахим хичээлд 515 сурагч хамрагдахаас 430 сурагч хамрагдаж, хамрагдалтын хувь 83.5 хувьтай байна.

/Ковид-19/-ын тохиолдол нэмэгдэж байгаатай холбогдуулан ахмадуудыг дасгал хөдөлгөөнөөр идэвхтэй хичээллүүлэн дархлааг сэргээх, дэмжих, сайжруулах зорилгоор “Дасгалаа хийж-Дархлаагаа дэмжье” ахмадын дунд зохион байгуулагдсан чалленжид Баруунбүрэн сумын ахмадын хорооны нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй оролцлоо.

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2021 оны А/28 тоот тушаал, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд улс орон даяар зохион байгуулагдаж буй “Эрүүл мэндийн цахим гүйлт 2021” гүйлтийн уралдаанд сумын иргэн Ж.Тогтох оролцож 14 хоногийн хугацаанд нийт 206.6 км газрыг туулсан. Мөн Спорт цогцолборын багш, дасгалжуулагч Б.Бат-Орших 142 км, Спорт цогцолборын арга зүйч Ц.Лхагвадэлгэр 18 км газрыг туулж оролцлоо.

*Коронавирусийн халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд:* Сумын хэмжээнд коронавируст халдварын 3 тохиолдол бүртгэгдэж сумын Засаг даргын 2021 оны 04-р сарын 07-ны өдрийн “Хязгаарлалтын дэглэм тогтоож зарим үйл ажиллагааг түр хориглох тухай” А/55 тоот захирамжаар сумын хэмжээнд хүнсний дэлгүүр, эмийн сан, ШТС-уудаас бусад бүх төр, төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг зогсоож, сумын Онцгой комиссын Шуурхай штабын Тандалт судалгааны баг халдвар илэрсэн иргэдийн ойрын хавьтлуудыг тодорхойлон ажиллаж, сумын хэмжээнд иргэдийн хатуу хөл хориог тогтоосон тул 8 хэсэгт хөдөлгөөнт эргүүлийн баг ажиллан иргэдийг гэрээсээ гарахгүй байхыг анхааруулж, хөдөлгөөний хязгаарлалт тогтоож ажиллалаа. Мөн гэрийн тусгаарлалт, ажиглалтад орсон айл өрхүүдээс утсаар захиалга авч өдөр бүр хүнсний бүтээгдэхүүн, эм, эмнэлгийн хэрэгсэл, ус түгээх хүргэлтийг гүйцэтгэн ажиллаж байна.

Сумын Онцгой комиссоос “Бид хариуцлагатай Баруунбүрэнчүүд” уриалгыг иргэдэд сурталчлан ажиллаж бүх худаг уст цэгүүдэд гар ариутгагч санитол, зөвлөмжийг байрлуулан ажилласан. Ариутгал халдваргүйтгэлийн баг өдөр бүр сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй байгууллага, хүнсний дэлгүүр, эмийн сан, худаг уст цэг, нийтийн эзэмшлийн зам талбайг ариутгаж давхардсан тоогоор 65 объект, нийтийн эзэмшлийн 31044 м.кв талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийсэн байна.

Аймгийн Онцгой комиссын шийдвэрийн дагуу сумын хэмжээнд гарсан /Ковид-19/ халдварыг түргэн шуурхай илрүүлэх зорилгоор 04 дүгээр сарын 12-ны өдөр аймгийн Онцгой комиссын дарга Ш.Оргил, аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Ж.Од нараар

ахлуулсан Эрүүл мэндийн оношилгооны 10 баг, халдваргүйтгэлийн 1 баг, татан авалтын 1 баг бүрэлдэхүүн суманд ажиллаж нийт 1160 иргэнээс түргэвчилсэн оношилгуурын шинжилгээг авч, сумын хэмжээнд халдварын голомтуудыг тогтоон хяналт тавин ажиллаж байна.

Мөн сумын Шуурхай штабын Мэдээлэл, харилцааны баг өдөр бүр сумын төвөөр иргэдэд санамж, зөвлөгөөг цагаан хоолойгоор дуут мэдээллийг зарлан ажиллаж байна.

Сумын хэмжээнд мал төлөлт нийт 78 хувийн үзүүлэлттэй байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” А/70 тоот захирамж, сумын Засаг даргын 2021 оны 03-р сарын 19-ний өдрийн “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэмцэх арга хэмжээний тухай” А/35 тоот захирамжийн дагуу сумын нутаг дэвсгэрт ой, хээрийн түймэр гарах байгалийн нөхцөл бүрдсэн хуурайшилтын үе буюу 03 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд ойд мод бэлтгэх, ойн дагалт баялгийг ашиглах, ойд аялал зугаалгаар явах, ан хийх, бугын эвэр түүр болон бусад үйл ажиллагаа явуулахыг хориглож сумын фэйсбүүк хуудсаар тогтмол иргэдэд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хууль эрх зүйн мэдээ мэдээлэл, зурагт хуудсуудыг сурталчлан ажиллаж байна.

#### **Баянгол сум:**

Засгийн газрын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны А/108 тоот захирамжийг сум орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэн улс, аймгийн Онцгой комиссоос ирүүлсэн заавар зөвлөмжийг удирдлага болгон ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2020 оны “Шуурхай штаб байгуулж ажлын тусгай горимд шилжүүлэх тухай” А/254 дүгээр захирамжийн дагуу Засаг даргын Тамгын газрын байранд шуурхай штабыг байрлуулан 24 цагийн хариуцлагатай жижүүрийг томилж, үүссэн нөхцөл байдалтай холбоотой мэдээ, мэдээллийг аймгийн Онцгой комисс болон холбогдох байгууллагад 94244802 дугаарын утсаар болон цахимаар [Bayangolshuurhaishtab@gmail.com](mailto:Bayangolshuurhaishtab@gmail.com) хаягаар хүргүүлэн ажиллаж байна.

Сумын хэмжээнд Цагдаагийн хэсэг, Гал түймэр унтраах 40-р анги, Улсын нөөц, хүмүүнлэг тусламжийн анги, Ерөнхий боловсролын сургууль, Баянгол цэцэрлэг, Засаг даргын Тамгын газар хамтран 24 цагийн пост 2 цэгт 4 албан хаагч үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2021 оны “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” А/56, “Түр хугацаанд хязгаарлалт тогтоох тухай” А/65 дугаар захирамжийн дагуу 04 дүгээр сарын 10-25-ны өдрийн 00:00 цаг хүртэл сумын төвөөс орох, гарах зорчих хөдөлгөөнийг хязгаарлаж, сум доторх хөдөлгөөнийг хэвийн үргэлжлүүлж, 08:00-22:00 цагийн хооронд төр төсвийн байгууллагын 24 ажилтан, алба хаагч 12 цэгт эргүүлийн үүрэг гүйцэтгэн хориглосон хугацаанд 18 градусаас дээш агууламжтай согтууруулах ундааны зүйлсийг худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосон.

Сумын Засаг даргын 2021 оны А/64 тоот “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тухай” захирамжийн дагуу Ой хээрийн түймэр гарч болзошгүй түймрийн аюултай үе эхэлж байгаатай холбогдуулан ойд мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах, аялал зугаалгаар явах, ан хийх болон бусад үйл ажиллагааг явуулахыг сумын нутаг дэвсгэрийн хүрээнд түр хугацаанд зогсоосон.

04 дүгээр сард /Ковид-19/-ын халдварыг илрүүлэх түргэвчилсэн шинжилгээг 56 иргэнд, ПГУ шинжилгээг 67 иргэнд тус тус хийж, сумын шалган нэвтрүүлэх постоор нэвтэрч буй 182 авто машин, байгууллагын 28942 м2 талбай, Ерөнхий боловсролын сургуулийн 126 м2 талбайд тус тус ариутгал хийсэн.

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээллийг “Баянгол ЭМТ” цахим хаягаар болон тараах материалаар иргэдэд хүргэн ажиллаж байна.

Аймгийн ХХААГ-ын даргын 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 95 тоот албан бичгийн дагуу Засгийн газраас “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-нд тусгагдсан “Ажлын байрыг дэмжих 2 их наяд төгрөгийн зээл”-ийн хүрээнд 04 дүгээр сарын 21-ний өдрийн байдлаар 5 иргэнд 133,0 сая төгрөг, 4 аж ахуй нэгжид 300,0 сая төгрөг нийт 533,0 сая төгрөгийн зээл олгоод байна.

Сумын Эрүүл мэндийн төвтэй хамтран аймгийн “Сэлэнгэ Ариутгал” ХХК мэргэжлийн байгууллага хүнсний худалдаа, нийтийн хоолны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг иргэн ААН-ийн нийт 2250 м2 талбайд ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийсэн.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2021 оны 18/02 тоот байнгын удирдамжийг баримтлан Баян 2 дугаар багийн “Тариат”, “Мухар”, “Хар морьт”, “Наран”, Гонир 3 дугаар багийн “Их Таширын нуруу”, “Урт хамар” гэх газруудаар холбогдох байгууллагын алба хаагчид шалгалтын ажлыг хийж, Баян 2 дугаар багийн “Хар морьт” гэх газар “Минж Наран Энэрэх” нөхөрлөлийн талбай дээр үйл ажиллагаа явуулж буй иргэдийг шалгахад нөхөрлөлийн болон холбогдох бичиг баримтгүй байсан тул үйл ажиллагааг зогсоож huandai-3000 Ic-7 гэх ЭКГ-ийн асаах төхөөрөмж болон компьютерыг түр хураан авсан тэмдэглэл үйлдэж, хураан авч, заавар зөвлөгөө өгч ажилласан.

Гонир 3 дугаар багийн “Бороо гоулд” ХХК-ий тусгай зөвшөөрлийн талбайд хэсэг бүлэг хүмүүс зохих зөвшөөрөлгүй газрын хэвлийг хөндөж цооног гаргасан байсныг илрүүлж, үйл ажиллагааг нь зогсоож зөрчил үйлдсэн Улаанбаатар хотын Налайх дүүргийн 8 иргэн, мөн тухайн газраас зүүн зүгт 3 км зайд жалганд байрлах 2 гэрт байсан 3 нийт 11 иргэнийг сумын төвд байрлах тусгаарлах байранд шилжүүлсэн. Шалгалтаар ачааны 1 автомашин, 1 цахилгаан үүсгүүр /мотор/-ийг түр хурааж сумын цагдаагийн хэсгийн журмын хашаанд журамласан.

Хуурайшилтын үе эхэлсэнтэй холбогдуулан ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг цахим орчинд байршуулан, ой, хээрийн бүс нутагт амьдардаг малчин өрхүүд, ААНБ-уудтай хариуцлагын гэрээ байгуулах ажил хийгдэж байна.

### **Ерөө сум:**

Сумын Онцгой комисс цаг үеийн байдал болон аймаг, улсын Онцгой комиссын гаргаж буй шийдвэрийг үндэслэн 11 удаа хуралдаж холбогдох шийдвэрүүдийг гарган ажилласан байна. Мөн сумын Онцгой комиссоос 522 иргэн яаралтай бичиг гаргуулж, асуудлаа шийдвэрлүүлсэн байна.

Мэдээлэл сурталчилгааны ажлын хэсэг “Ерөө сумын Онцгой комисс” Фасебүүк хуудсаар дамжуулан иргэдэд Коронавируст халдвар /Ковид-19/-ын талаар улс, аймаг, сумын цаг үеийн мэдээ 27, анхааруулга мэдээ мэдээлэл 8, уриалга зөвлөмж 14, сумын Онцгой комисс хурал 6, автомашинтай цагаан хоолойгоор мэдээ мэдээлэл 2, хандивын талархал мэдээ 1 удаа тус тус хүргэсэн байна.

Нөхцөл байдалтай холбогдуулан өдрийн хариуцлагатай жижүүрээр 16 албан хаагч, хяналтын постод ЗДТГ-ын 6, төр төсвийн 16, Буурагчин, Тавин багийн хэсгийн 9 дарга нийтдээ 47 албан хаагч үүрэг гүйцэтгэж байна.

### **Хууль, эрх зүй, сургалт сурталчилгааны ажлын хүрээнд:**

1. Архив албан хэрэг хөтлөлтийн тухай “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам” шинэчлэн батлагдсантай холбоотой албан хаагчдын сургалтад төр, төсвийн байгууллагын 5 бичиг хэргийн ажилтан
2. “Мал эмнэлгийн салбарт хийсэн үнэлгээ ба шийдэл” сэдэв сургалтад Мал эмнэлгийн тасгийн 2 албан хаагч
3. Ойн хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгааны ажлыг 30 айл өрхийн 62 иргэнд сурталчилгааны ажлыг хийсэн байна.
4. Ерөө сумын Засаг даргын Тамгын газрын мэдээ “Фэйсбүүк” хуудсаар дамжуулан 16 албан хаагч 90 төрлийн мэдээ мэдээллийг иргэдэд тус тус хүргэж ажилласан байна.
5. “Ковид-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Зөвлөмж” мэдээллийг 2-р багийн тасгийн 40 өрхийн 40 иргэнд хүргэсэн байна.

Ажил хайгчаар бүртгүүлсэн 12 иргэнийг “Болд төмөр Ерөө гол” ХХК-ий хүний нөөцийн албанд хүргүүлж, шинэ ажлын байранд 10 иргэнийг зуучилсан байна.

Сумын номын сангаас цахим хэлбэрээр 25 өгүүллэг хүргэж 120 хүнд хүргэсэн.

Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан “Ковид-19” халдварт өвчний вакцинжуулалтад сумын хэмжээнд эрүүл мэнд, ерөнхий Боловсролын сургуулийн ажилчид, цагдаа, сумын Онцгой комиссын гишүүд, стратегийн ач холбогдол бүхий газрууд болох дулаан, цахилгаан, ШТС, хүнс үйлдвэрлэл, харилцаа холбоо, ачаа тээвэр, тариаланч, ногоочдыг хамруулах чиглэлийн дагуу вакцинжуулалтад 598 иргэн хамрагдаж 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Улаанбаатар хотоос болон бусад аймаг сумаас ирсэн иргэдэд түргэвчилсэн оношилгуураар 185 иргэнд, гэрийн тусгаарлалтаас гарсан болон эмнэлгийн ажилчид 113 иргэнд PCR шинжилгээнүүдийг тус тус хийж зөөвөрлөсөн байна.

Ойн санг гэрээгээр эзэмшигч 2 аж ахуй нэгж, 10 нөхөрлөлийн ахлагчтай хамтран “Түймрийн хариуцлагын гэрээ”-г байгуулсан. “Болд Төмөр Ерөө гол” ХХК-ий туслан гүйцэтгэгч “Инфинити спэйс” ХХК-ий талбай тусгаарлалтаас гарсан хус модноос 1, 2 дугаар багийн 10 өрхөд өгсөн байна.

Мал амьтны халдварт гоц халдварт шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд туулгалтад хонь 32674, ямаа 94869, үхэр 17657, адуу 6732, нохой 2484, гахай 932, нийтдээ 95375 мал амьтан, боловсруулалтад хонь 32674, ямаа 34896, үхэр 17657, нохой 475, гахай 220 нийт 85922 мал амьтныг, Шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад 15200 богийн төлийг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2021 оны “Үнийн дээд хязгаар тогтоох тухай” А/66 тоот захирамжийн дагуу үхрийн мах 12000-13000 төгрөг, хонины мах 8000-10000, ямааны мах 7000-9000 төгрөгт худалдаалахыг худалдаа үйлчилгээний аж ахуй нэгжүүдэд үүрэг болголоо.

Бизнесийн зориулалтаар хадлан бэлтгэдэг иргэдийн төлөөллийг халдвар хамгааллын дэглэм баримтлан уулзалт зохион байгуулж, хадлангийн газрын сэлгээн өнжөөх талаар санал солилцон 2021 онд бизнесийн зориулалтаар хадлан бэлтгэдэг газруудыг өнжөөхөөр шийдвэрлэсэн.

#### **Жавхлант сум:**

Сумын Онцгой комисс нийт 10 удаа, шуурхай штаб 11 удаа тус тус хуралдаж холбогдох шийдвэрүүдийг гарган ажил арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

“Ковид-19”-ын эсрэг вакцинжуулах ажлыг зохион байгуулж, эхний ээлжинд онцгой нөхцөл байдлын тэргүүн эгнээд ажиллаж байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн нийт 264 алба хаагчид 100 хувь хамрагдлаа.

Сумын шуурхай штаб тандалт судалгааны багийг байгуулан халдвартай бүс нутгаас 3 дугаар сарын 23-наас хойш ирсэн иргэдийн нарийвчилсан судалгааг гаргасан.

Сумын Эрүүл мэндийн төв нь тухайн сард 582 хүнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж, зөвлөгөө өгч, коронавирусын вакцинд зорилтот бүлгийн нийт 364 иргэн хамруулсан.

2020-2021 оны хичээлийн жилд бүрэн дунд боловсрол эзэмших 9 сурагч, суурь боловсрол эзэмших 24 сурагч төгсөж байна.

Том малын зүй бус хорогдол, төлийн мэдээг авч аймгийн ХХААГ-т хүргүүлж байна. Нийт 40111 үүнээс гүү 613, үнээ 2200, хонь 19347, ямаа 17951 мянган толгой хээлтэгч төллөж, төллөлтийн хувь 87 хувьтай байна.

Сумын хэмжээнд малчин болон мал бүхий иргэдэд 33 гарал үүслийн гэрчилгээ олгосон. Адууны мах 660 кг, үхрийн мах 4970 кг, хонины мах 25 кг, ямааны мах 200 кг тус тус олгож ажиллалаа.

### **Зүүнбүрэн сум:**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай”, “Дотуур байрны хүүхдийн хоол”, “Цэцэрлэгийн хүүхдийн хоол”-ны материал нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн урилгыг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим сайт болон Зууны мэдээ сонинд нийтэллээ.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/69 тоот захирамжийн хүрээнд “Тохижилт, ногоон байгууламж аян”-г сумын хэмжээнд зохион байгуулж эхний ээлжид сумын төвийн эвдэрсэн замыг тэгшлэх ажлыг хийж байна.

“Уран жиргээ-2021” уран уншлагын наадам болон “Дунгийн эгшиг-2021” шүлэг зохион бичих уралдааныг тус тус зохион байгуулж, уралдаанд 10 сурагч оролцсоноос эхний 3 байранд шалгарсан сурагчдыг урамшууллаа.

Хичээл сургалтын үйл ажиллагааг түр зогсоосон хугацаанд 11 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 124 багш, албан хаагч хамрагдаж, 510 сурагчдаас теле хичээл үздэг 396, үздэггүй 141 сурагчдын судалгааг анги тус бүрээр гаргалаа.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдаж буй хүүхдүүдэд зориулсан теле хичээлд 115 суралцагчийг хамрууллаа.

Хүүхэд хамгааллын чиглэлээр цахим орчинд 18 бүлгийн эцэг эхийн, бүлэг болон чатаар 15 төрлийн мэдээллийг 350 гаруй эцэг эхэд түгээлээ.

Сумын хэмжээнд мал төллөлт 71.9, төл бойжилт 99.6 хувьтай байна.

“Мал амьтны халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх, сэг зэм устгах, ариутгал халдваргүйтэлийн сарын аян”-ы хүрээнд нийтийн эзэмшлийн талбай 1958 м<sup>2</sup>, 43 малын хашаа хороо 2429 м<sup>2</sup>, нийт 4494 м<sup>2</sup> талбайг, хүнс, худалдаа хүргэлтийн 12 тээврийн хэрэгслийг халдваргүйжүүллээ.

“Мал эмнэлгийн ажил үйлчилгээг хэрэгжүүлэх нэгдсэн арга хэмжээ”-ний хүрээнд төл малын шөвөг яр өвчний дархлаажуулалтын ажлыг зохион байгуулж 5186 толгой төл мал хамруулсан нь 21 хувьтай байна.

Бэлчир багийн 30 өрхөд “Малчин өрхөд мал үржил, мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн мөрдөлтийг шалгах хяналтын хуудас”-аар хяналт явуулж Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7.3.1-д заасны дагуу мал, амьтан маллагч малын эмчийн



зааврын дагуу өвөлжөө хаваржаа болон эрчимжсэн мал аж ахуйн ойр орчимд малын хүүр сэг зэм биологийн хаягдал устгах зориулалтын цэг байгуулах талаар мэдэгдэл өгч, малын өрхийн эрүүл мэндийн дэвтэр хөтлөлтөд хяналт тавьж “Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль”-ийн 26.3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллалаа.

Малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавин ажиллаж Төв аймгаас тээвэрлэн яваа 2 өрхийн 350 хонь, 23 үхэр, 15 адууны малын эрүүл мэндийн гэрчилгээтэй танилцаж, 3 тээврийн хэрэгслийг халдваргүйжүүллээ.

Азийн хөгжлийн банк, ядуурлыг бууруулах Японы сангийн санхүүжилтээр “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл” С/L3895/L3896/G9205/-ийг Зүүнбүрэн сумын “Охиндойн” талын 2670 га талбайд хэрэгжүүлэхэд эрх ашиг нь хөндөгдөж буй Жаргалант 1 дүгээр багийн 351, Бэлчир дугаар багийн 330 өрх, нийт 681 өрхөөс саналын хуудсаар санал авч ажлын хэсгийн дүгнэлтээр холбогдох дээд шатны байгууллагад хүргүүллээ.

#### **Мандал сум:**

Сумын Засаг даргын 2021 оны “Коронавируст /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай” А/65, А/84 тоот захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тус сард сумын хэмжээнд Коронавируст /Ковид-19/ цар тахлын батлагдсан тохиолдол 12 бүртгэгдэж цаашид нэмэгдэх хандлагатай байгаа тул сумын Онцгой комиссын 2021 оны 02 тогтоолын дагуу хүнсний худалдаа эрхлэгчдээс бусад худалдааны үйл ажиллагааг түр зогсоож, сумын хэмжээнд 3 хоногийн турш авто машины хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээг авч ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Бүх нийтийн халдваргүйжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх тухай” А/15 дугаар захирамж, сумын Онцгой комиссын шийдвэрийн хүрээнд сумын дотор төв зам дагуу 730,0 м<sup>2</sup> талбай, 206 аж ахуй нэгж байгууллагын 17253 м<sup>2</sup>, 61 орон сууцны орц хонгил 11709 м<sup>2</sup> талбайд ариутгал халдваргүйтгэлийг хийлээ.

Коронавируст /Ковид-19/-ын эхний тунгийн вакциныг стратегийн ач холбогдол бүхий байгууллагууд болох эмнэлэг, сургууль, цэцэрлэг, соёл, урлагийн байгууллага, цагдаа, онцгой байдлын газрын албан хаагч нийт 3321 хүнийг хамрууллаа.

2020-2021 оны хичээлийн жилийн шилдэг илтгэл шалгаруулах уралдааны үндэсний хэмжээний хэлэлцүүлэг зохион байгуулагдаж Мандал 4 дүгээр сургуулийн баг хамт олон тэргүүн байранд шалгарлаа.

Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрсдэлд орж болзошгүй хүүхдийн судалгаа мэдээллийг гарган хяналт тавих, нөлөөллийн ажлыг зохион байгуулах зорилгоор сумын хамтарсан багуудын дунд “Манлайлагч хамтарсан баг” нэг сарын аяныг зохион байгуулан ажиллаж байна.

Зүүнхараа хүүхдийн ордны 4 насны ангиллаар хичээллүүлдэг 5 төрлийн дугуйланд 90 хүүхэд цахимаар даалгавраа хүлээн авч, хамрагдлаа.

Сургууль, цэцэрлэг, соёл, урлаг, спортын байгууллагын цахим хуудсаар дамжуулан 12 төрлийн 147 мэдээлэл нийтэлж, иргэдэд зориулсан ном сурталчилгааны болон танин мэдэхүйн мэдээллийг хүргэж 8377 хандалттай байна.

Сумын амьжиргаа дэмжих зөвлөл тайлант сард 2 удаа хуралдаж байнгын асаргаа шаардлагатай ахмад настан шинээр 3, сунгалт 2, асрагч солих 1, хөгжлийн бэрхшээлтэй иргэн шинээр 1, сунгалт 5, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд шинээр 3, сунгалт 4 нийт 19 иргэний өргөдлийг шийдвэрлэж ажиллалаа.

Засгийн газрын 2019 оны 179 дүгээр тогтоолоор малчдад олгох урамшууллыг “Төсвийн урамшууллын систем”-ээр дамжуулан тооцоолж тухайн цаг хугацаанд нь малчдад олгох болсонтой талаар мэдээлэл бэлтгэн цахимаар 750 малчин, мал бүхий иргэдэд хүргүүлсэн байна.

Аймгийн ХХААГ, Зээлийн батлан даалтын сан, Хөгжлийн шийдэл ТББ, сумын Засаг даргын Тамгын газар хамтарсан жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 20 иргэн, ААН-д зээлийн батлан даалт, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчийн талаар, төсөл хэрхэн бичих талаар цахим сургалтыг зохион байгууллаа.

Сумын Засаг даргын 2021 оны “Зээл олгох тухай” А/73 тоот захирамжийн дагуу төсөл хэрэгжүүлэгч 11 иргэнд сум хөгжүүлэх сангаас 105 сая төгрөгийн зээл олголоо.

Сумын хэмжээнд шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2550 толгой мал амьтныг хамрууллаа.

Ширхэнцэг 2 дугаар баг, Баянсуудал 3 дугаар баг, Минжийн хангайн 7 дугаар баг, Баян-арцат 9 дүгээр багуудад хаврын сэг, зэм устгал, ариутгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулж 1 адуу, 45 үхэр, 1 хонь, гахай 10, нийт 56 толгой мал амьтны сэг зэмийг устгалд оруулж, 5747 м<sup>2</sup> бэлчээрийн талбайд ариутгал халваргүйтгэл хийсэн байна.

Малын шилжилт хөдөлгөөнд байнгын хяналт тавих, малын гоц халдварт өвчин дамжих эрсдэлийг багасгах, малын хулгайтай тэмцэх, мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, гарал үүсэл нь тодорхой, эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнийг нийтийн хэрэгцээнд нийлүүлэх, мал эмнэлгийн арга хэмжээг технологийн хугацаанд гүйцэтгэж байгаа эсэхэд хяналт тавьж нийт 21 адуу, 140 үхэр, 148 хонь, 16 ямаа, 10 гахай, адууны мах 560 кг, ямааны мах 260 кг, үхрийн мах 24741 кг, хонины мах 7510 кг, тэмээний мах 1420 кг, үхрийн сүү 550769 литр сүү, 2050 кг ноолуурт гарал үүслийн гэрчилгээ бичиж олгосон байна.

Мах махан бүтээгдэхүүний мал эмнэлгийн магадлан шинжилгээний QR код олгох ажлыг нэвтрүүлэх зорилгоор мах бэлтгэлийн төвд ажлын 8 цагаар мал эмнэлэг үйлчилгээний нэгжүүд магадлан шинжилгээний QR код олгож нийт 141 толгой мал амьтны түүхий эд бүтээгдэхүүнд хяналт тавьж ажилласан.

Хэрэглээний мод бэлтгэх эрхийн бичгийг 3 ААНБ-д 272 м<sup>3</sup>, 16 иргэнд 98 м<sup>3</sup> түлээний эрхийн бичиг олгож, 28 гарал үүслийн гэрчилгээнд нийт 1047 м<sup>3</sup> бичиж олголоо.

Ойн сан бүхий газарт нутаглаж буй 89 малчин айл өрхтэй хуурайшилтын үеийн хариуцлагын гэрээ байгуулан түймрээс урьдчилан сэргийлэх гарын авлага тараан ухуулга сурталчилгаа хийж, сумын Засаг даргын 2021 оны “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, ажлыг зохион байгуулах тухай” А/56 захирамжийн хэрэгжилтийн хүрээнд хуурайшилтын мэдээг аймаг, сумын холбогдох газруудад мэдээллийг хүргэж, цар тахалтай холбоотойгоор Ойн ангийн ажилчид хуурайшилтын үеийн хариуцлагатай жижүүрийг ээлжлэн гүйцэтгэж байна. 16 нөхөрлөл, 9 ААНБ-ын 39 хүнд идэвхтэн байгаль хамгаалагчийн үнэмлэхийг аймгийн БОАЖГ-ын даргатай гэрээ байгуулан шинэчлэн олголоо.

#### **Орхон сум:**

Улс, аймгийн Онцгой комиссын шийдвэрийн дагуу төр, төсвийн байгууллага, дулаан цахилгаан, ШТС, цэвэр бохир усны шугам сүлжээний ажилчид, тариаланчид, ногоочид зэрэг 382 иргэн /Ковид-19/ цар тахлын эсрэг дархлаажуулалтад хамруулж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/15 “Бүх нийтийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх тухай” захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 18 ААН, байгууллагын давхардсан тоогоор 27150 м2 талбайд халваргүйжүүлэлт хийгдсэн.

Сумын Засаг даргын 2021 оны “Ой, хээрийн түймрээс хамгаалах урьдчилан сэргийлэх тухай” А/25 тоот захирамжийн хэрэгжилтийн хүрээнд малчин өрх болон отроор ирж тус суманд өвөлжсөн айл өрхүүдэд үнс нурмаа ил асгахгүй байх, өвс малын бууц, хог хаягдлыг шатаахгүй байх талаар сэрэмжлүүлэг мэдээ өгч, түймрийн мэдэгдлийг 215 айл өрхөд хүргэлээ. Мөн төр, төсвийн байгууллагуудаар ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх 30 ширхэг түймрийн цохиур, 15 тросон шүүрнүүдийг хийлгэж хүлээн авлаа. Мөн ажлын хүрээнд түймрийн үлээгч 2 ширхгийг авч бэлтгэл бэлэн байдлыг ханган ажилласан.

“Ковид-19” цар тахалтай холбоотой зөвлөмж, анхааруулга, улс, аймаг, сумын Онцгой комиссын шийдвэр, мэдээ мэдээллийг шторк хэлбэрээр хүргэх ажлыг сумын ФВ хаягуудыг ашиглан иргэдэд хүргэн ажиллаж байна.

Байнгын 24 цагийн болон хяналтын постыг тогтмол ажиллуулж байна.

Баруунбүрэн суманд “Ковид-19” халдварын батлагдсан тохиолдол бүртгэгдсэнтэй холбоотой “Айл хүний-Амь нэг” уриан дор иргэний санаачлагыг дэмжиж хандивын аяныг зохион байгуулж байна.

“Эрүүл мэндийн цахим гүйлт-2021” уралдаанд төр төсвийн байгууллагын 40 төрийн албан хаагчийг хамрууллаа.

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 05 тоот тогтоол, сумын Засаг даргын 2021 оны А/14 тоот “Бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулах тухай” захирамжийн хүрээнд сумын хэмжээнд нийтийн эзэмшлийн гудамж талбай, засмал зам дагуух хог хаягдлыг цэвэрлэх ажилд 8 төрийн болон төрийн бус байгууллагын 54 албан хаагч, ажилчид 8 га газрын 6 тн ил задгай хог хаягдлыг цэвэрлэн сумын төвийн төвлөрсөн хогийн цэгт ачиж буулгах ажлыг зохион байгуулсан.

Засгийн газрын 2016 оны 153-р тогтоол “Сум хөгжүүлэх сан”-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 3.3.1 дэх заалтыг үндэслэн сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн тэргүүлэх чиглэлийг

1. Малын тэжээлийн үйлдвэрлэл
2. Гурил гурилан бүтээгдэхүүний цех
3. Зоорь
4. Нийтийн ахуй үйлчилгээ/үсчин, гутал, оёдол, эсгүүр гэх мэт/
5. Төмс хүнсний ногооны тариалалт зэргээр баталсан.

Сум хөгжүүлэх сангийн зээлэнд хамрагдахаар 11 иргэн 146,500,0 төгрөгийн төсөл бичиж ирүүлснээс 9 иргэний 89000,0 сая төгрөгийн төслийг дэмжсэн.

Сумын хэмжээнд 43131 толгой хээлтэгч эх мал төллөхөөс 70,9 хувь нь төллөсөн байна.

#### **Орхонтуул сум:**

Сумын Онцгой комиссын 2021 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 01 тоот тогтоолоор нийт төр төсвийн байгууллагын албан хаагчдын бүрэлдэхүүнтэй эргүүл томилон хуваарь гаргаж үйл ажиллагаа явуулж буй худалдаа үйлчилгээний газрууд, банкнуудад бөөгнөрөл үүсгэхгүй халдвар хамгааллын дэглэмийг сахиулан иргэдэд шаардлага тавин ажиллалаа. Мөн сумын шуурхай штабын жижүүрүүд тандалтын багаар өдөр бүр тусгаарлалтад байгаа айл өрхүүддээ хяналт шалгалт хийн, сумын хэмжээнд 2 пост гарган хуваарийн дагуу үүрэгт албан хаагчид 15 өрхийн 22 иргэн,

түүний хамаарал бүхий 36 иргэн нийт 58 иргэнийг 10 хоногийн гэрийн тусгаарлалтад хяналт тавин ажиллаж байна.

Сумын хэмжээнд коронавируст халдвар /Ковид-19/-ын вакцинжуулалтыг 2021 оны 04 дүгээр сарын 04,05-ны өдрүүдэд зохион байгуулж, тэргүүний ээлжид хийх 323 иргэнийг хамрууллаа.

“Бүх нийтийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх тухай” сумын Засаг даргын А/56 захирамж гарган нийт төр төсвийн байгууллагуудад халдваргүйтгэлийн баг гаргаж өдөр бүр 2 цаг тутамд ариутгал хийж ажиллаж байна.

Сумын Онцгой комиссоос цар тахлаас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах зорилгоор “Халдварт өвчний эсрэг хамтдаа хичээцгээе” хандивын аяныг өрнүүлэн одоогоор нийт 1.010.0 төгрөг цуглараад байна.

Цар тахалтай холбоотойгоор хөл хорио тогтоосон үед цахим хэлбэрээр “Хүүхдийн аюулгүй байдлыг хэрхэн хангах”, архины хор нөлөөг цуврал хэлбэрээр [Orkhontuul@selenge.gov.mn](mailto:Orkhontuul@selenge.gov.mn) цахим хуудас, Орхонтуул ЗДТГ фэйсбүүк хуудсаар дамжуулан иргэдэд тогтмол мэдээлэл түгээн ажиллаж байна.

Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний дэлгүүрүүд, хоолны газруудад коронавируст халдварын үед дагаж мөрдөх түр журмын хэрэгжилтийг хангуулах зорилгоор хяналт шалгалтын ажлыг хийлээ.

Сумын хэмжээнд мал төллөлт 90 хувь, бойжилтын 98.9 хувьтай байна.

#### **Сайхан сум:**

Коронавируст /Covid-19/ халдвараас урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 5 хоногийн хугацаанд зохион байгуулж, 1371 иргэнийг хамруулан ажиллалаа.

“Хуванцар бохирдолтой тэмцэх” сэдвийн хүрээнд “Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хэвшүүлэх” ажил зохион байгуулж “Хандлагаа өөрчилье”, “Хог бүү хая” зэрэг уриалга, санамж, зөвлөмжийг 210 ширхэг хэвлэн иргэд олноор үйлчлүүлдэг газруудад байршуулан иргэдэд хүргэж ажилласан.

Байгаль орчны хяналтын чиглэлээр сум дундын цагдаагийн хэлтэстэй хамтран төлөвлөгөөт хяналт шалгалтыг 1 удаа, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 1 удаа тус тус зохион байгуулж ажилласан. Тус ажлын хүрээнд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй газрын хэвлийн ашигласан 1 иргэнд “Зөрчлийн тухай хууль”-аар 150.0 төгрөгийн торгууль, шийтгэлийн арга хэмжээ авч, 130 кг хээрийн саарал чулууг хураан авч, устгалд орууллаа.

Сумын хэмжээнд нийт 26378,5 га эргэлтийн талбайтай үүнээс 2021 онд үр тариа 13257,8 га-д, төмс 250 га хүнсний ногоо 170 га-д тариалалт хийхээр судалгааг гаргаж холбогдох газарт хүргүүлэн ажилласан.

Үр тарианы хувьд иргэн ААНБ-ууд “Алтайская” 75, “Буриатская оцестая”, “Дархан” 131,144, “Сэлэнгэ” зэрэг соортуудаар тариалалт хийхээр бэлтгэсэн. Сумын нийт үр тарианы 32 ААН-ээс 26 буюу 96,6 хувь, 25 иргэнээс 8 иргэн буюу 47,2 хувь нь хаврын тариалалт хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Том малын зүй бус хорогдол 111, мал төллөлт 42207 буюу 72.8 хувьтай явагдаж байна.

Хорио цээрийн дэглэмийн үед аж ахуй нэгж байгууллагуудаар тогтмол өдөр тутмын ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэж эрсдэл өндөртэй 10 байгууллагын 258.914 м2 талбай ариутгаж, /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор сумын 73.838 м2 талбайд халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэлээ.

Коронавирусын халдвар /Covid-19/-аас урьдчилан сэргийлэх зөвлөмжүүдийг сумын аж ахуй нэгж байгууллагуудад хүргүүлж 7 хоногт 2 удаа 10-15 үйлчилгээний байгууллагуудаар хяналт шалгалт хийсэн.

Сумын 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу цахим тендер шалгаруулалтын үнэлгээний хорооноос 2, 3-р сард зарлагдсан тендер оролцогч байгууллага санал ирүүлээгүйн улмаас үр дүн гараагүй 5 тендер дахин зарлаад байна.

Засгийн газар, Соёлын Яамнаас хэрэгжүүлж буй цуврал, “Цахим орчинд соёл түгээе” аяны хүрээнд, цахим орчинд эерэг хандлагыг төлөвшүүлэх зорилгоор тус сумын соёлын ордны хамт олон “Миний сурч, хийж буй ажил” 7 хоногийн аян зохион байгуулж, иргэдийг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор эмэгтэйчүүдийн холбоотой хамтран “Зөв хооллолт, зохистой хөдөлгөөн” сэдэвт илүүдэл жингээ хасах сарын аяныг эхлүүлж өглөөний алхалт, оройн гимнастик, дасгал хөдөлгөөнд хамруулж байна.

Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан “Тогтвортой хөгжлийн боловсрол төсөл II”-ын хүрээнд зохион байгуулагдсан “Дэлхийн том хичээл” уралдаанд тус сумын сургуулийн багш нар хамтран 3 хичээл бэлтгэн явуулснаас “Жендэрийн тэгш байдал” сэдэвт хичээл аймгийн хэлэлцүүлэгт орж 3 хичээлээс улсын хэмжээний хэлэлцүүлэгт орох 9 хичээлд шалгарсан байна.

Тохижилт үйлчилгээний хэсгийн цахилгаанчин, засварчин Орон сууц хорооллын 1,6 км замын хайс хашлагын гадна дотор байрлах дэрсийг уг үндсээр нь гарган авч цэвэрлэгээ хийгдсэн. Мөн ногоон байгууламж дахь 8898,1 м2 талбайд байрлах 90 тооны дэрсийг үндсээр нь сугалан авч цэвэрлэсэн.

Сумын хэмжээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цэцэг үрсэлгээний ажил эхэллээ. Мөн ард иргэдийн эрүүл орчинд аж төрөх нөхцөлийг бүрдүүлэх томоохон ажлын нэг болох нийтийн эзэмшлийн зам, гудамж, талбайд ургасан харшил үүсгэгч зэрлэг ургамал, шарилж зэргийг тогтмол хугацаанд түүх цэвэрлэгээ тус тус хийгдсэн байна.

#### **Сант сум:**

04 дүгээр сарын 04-08-ны өдрүүдэд сумын хэмжээнд (Ковид-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулах ажлыг халдвар хамгааллын дэглэмийг мөрдөн зохион байгуулж 1-р ээлжид зорилтот бүлгийн 219, 2-р ээлжид зорилтот бүлгийн 250 нийт 469 иргэнийг вакцинд хамрууллаа.

Дархлаажуулалтын ажил зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан сумын нутаг дэвсгэрт 04 дүгээр сарын 07-14-ны өдрийг хүртэл 7 хоногийн хугацаанд архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох тухай сумын Засаг даргын А/43 дугаар захирамж гарч хэрэгжилтийг ханган ажиллалаа.

(Ковид-19) цар тахлын халдварын тархалт нэмэгдэж зэргэлдээ Баруунбүрэн, Хушаат, Сайхан сумдад халдварын тохиолдол бүртгэгдэн эрсдэл нэмэгдэж байгаа тул сумын нутаг дэвсгэрт орох, гарах хөдөлгөөнийг хязгаарлах зорилгоор шалган нэвтрүүлэх хяналтын пост, хөдөлгөөнт эргүүлийн тоог нэмэгдүүлж 4 чиглэлд байршуулж, төрийн албан хаагчид хуваарийн дагуу ажиллаж байна.

(Ковид-19)-ын халдварт өвчнөөс сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд сумын Эрүүл мэндийн төвөөс эмч, ажилчдыг чадавхжуулах сургалтыг 7 хоног бүрийн Пүрэв гарагт тогтмол зохион байгуулж нийт 4 удаагийн сургалтаар давтан тоогоор 42 эмч, эмнэлгийн ажилчдыг хамруулсан. Мөн шуурхай штабын удирдлага, бүлгүүдийн ахлагч нарт (Ковид-19) цар тахлын халдварын эрсдэлт нөхцөлд хэрхэн

ажиллах, бүлгүүдийн зохион байгуулалт төлөвлөлтийг хэрхэн хийх талаар чиглэл олгох 2 удаагийн сургалтыг зохион байгууллаа.

Улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдалд шилжсэнтэй холбогдуулж хүнсний болон бусад бараа бүтээгдэхүүний үнийн хөөрөгдөл гаргахгүй тал дээр анхаарч сумын худалдаа үйлчилгээ эрхлэгч 9 аж ахуйн нэгж, байгууллагад мэдэгдэл хүргүүлэн, хяналт тавин ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2021 оны А/38 тоот захирамжийн дагуу сумын төвлөрсөн хогийн цэгийн задгайрсан хогийг ангилж, цэвэрлэх ажлыг зохион байгууллаа. Төсвийн 5 байгууллагын 61 хүн оролцож 100 га нийтийн эдэлбэр газрын хуванцар савыг түүсэн.

Аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газар болон “Хөгжлийн шийдэл” ТББ-тай хамтран “Бизнес төсөл” сэдэвт онлайн сургалтыг зохион байгуулж 5 аж ахуйн нэгж, 15 иргэнийг хамрууллаа.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагааг түр хугацаагаар хойшлуулсантай холбогдуулан сумын хүүхэд хамгааллын хамтарсан багаас “Хүүхдийн эрхийн тухай хууль”, “Хүүхэд хамгааллын тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль”-ийг сурталчилж эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдэд гэрийн эргэлт хийж, хяналт тавьж ажиллахыг боловсролын байгууллагын удирдлага, анги даасан багш нарт үүрэг болголоо.

Сумын хэмжээнд цэцэрлэгт хамрагддаг 115 хүүхдээс 61 хүүхэд буюу 53 хувь нь теле хичээлээ үзэж байна. ЕБС-ийн I-V ангийн сурагчдын 86 хувь, VI-IX ангийн сурагчдын 84 хувь, X-XII ангийн сурагчдын 78 хувь нь теле хичээлээ үзэж байна. Теле хичээл үзэх боломжгүй байгаа сурагчдад анги, бүлгийн багш нар гарын авлага, нэмэлт даалгавар өгч ажиллаж байна.

“Дэлхийн Зөн Монгол” ОУБ-ын “Сэлэнгэ нутгийн хөтөлбөр”-өөс коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын үед дэмжлэг болох зорилгоор сумын зорилтот бүлгийн 100 өрх тус бүрт 100.000 төгрөгийн хүнсний дэмжлэг үзүүллээ.

Ардын хувьсгалын 100 жилийн ойг угтаж иргэдийг соён гэгээрүүлэх, цахим орчинд эерэг хандлага төрүүлэх зорилгоор сумын Соёлын төвөөс “Мөнхөд дуурсагдах 100 алдартнууд” цуврал цахим танилцуулгын ажлыг зохион байгуулж нийт 8 ахмад настныг алдаршуулж ажиллалаа. Цахим танилцуулгад нийт 54 ахмадуудын мэдээлэлд 204800 иргэний хандалт авсан байна.

#### **Сүхбаатар сум:**

Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоолын дагуу Коронавирус (Ковид-19) өвчнөөс урьдчилан сэргийлэх үүднээс ЗДТГ-ын нийт албан хаагчдын 30 хүртэлх хувийг ажиллуулж, албан хаагчдыг гэрээр ажиллуулах боломжийг ханган төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэж байна.

Сумын шуурхай штаб 24 цагаар ажиллан шаардлагатай иргэдэд сумаас орох гарах зөвшөөрөл олгож ажиллалаа.

Халдвартай бүс нутгаас ирсэн 467 иргэдийг гэрийн тусгаарлалт ажиглалтад авч 10 удаагийн давтамжтайгаар ПСР-ийн шинжилгээ авч хяналт тавин ажиллаж байна.

“Сүхбаатар сум ЗДТГ” цахим хаягт хууль эрх зүй, албан бичиг 1, сэрэмжлүүлэг мэдээ 11, зөвлөмж 10, мэдээ мэдээлэл 70, коронавируст (Ковид-19) халдварт өвчний цаг үеийн нөхцөл байдлын хэвлэлийн бага хурлыг 25, видео контент 13, мэдээ, мэдээлэл /захирамж, албан тоот, суманд хийгдэж буй ажлууд болон хийгдсэн ажлууд/ 130 тус тус тавьж иргэдэд мэдээ мэдээллийг хүргэн, Сүхбаатар сумын албан ёсны сайт дээр 5 мэдээг зурагт хуудастай хамт нийтэлсэн.

Аймгийн Засаг даргын А/108 дугаар захирамжийн дагуу аймгийн Мэргэжлийн хяналтын газар болон Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран махны худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийлээ. Мөн сумын Засаг дарга махны худалдаа эрхлэгч 20 гаруй аж ахуйн нэгж, иргэдтэй уулзалт зохион байгуулж, тулгамдаж буй асуудлын талаар харилцан ярилцаж, дараах асуудлуудыг шийдвэрлэлээ. Үүнд:

- Алтанбулаг, Ерөө, Зүүнбүрэн, Цагааннуур сумдын чиглэлд мах бэлдэх
- ЭМГ-тай хамтран түргэвчилсэн шинжилгээнд хамруулах
- Малын гарал үүслийн бичгийг түргэн шуурхай, чирэгдэлгүй олгож байх

Улаанбаатар хот болон бусад аймаг, орон нутгаас хүнс болон хүнсний бус ачаа тээвэрлэн ирж буй 97 тээврийн хэрэгслийг сэлгэн ачих буулгах талбайд хүлээн авч сэлгэн буулгахад хяналт тавин, тээврийн жолооч, борлуулалтын компанийн борлуулагч нарыг мэргэжил арга зүйн зөвлөмжөөр ханган ажиллаж “Ачаа тээврийг сэлгэн буулгах, ачих тухай” түр журам зөрчсөн 2 зөрчил, дутагдлыг илрүүллээ.

Оны эхний хээлтэгч мал 10334, үүнээс төллөх 8663, төллөсөн хээлтэгч 7370 буюу 85 хувьтай мал төллөөд байна .

Аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны 31/87 тоот албан бичгийн дагуу “Шар үерийн аюулаас урьдчилан сэргийлэх аян”-ыг сумын хэмжээнд 03 дугаар сарын 12-ны өдрөөс 04 сарын 14-ний хооронд зохион байгуулж иргэдэд мэдээ мэдээллийг цахим хэлбэрээр болон 8 багийн Засаг дарга нараар дамжуулан хүргэж гол, мөрөн, нуурын арал, тохой эрэг дагууд болон уулын ам, бэл, гүү жалга сувгийн ойролцоо айл, өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг суурьшихгүй байхыг анхааруулах, эрсдэл бүхий айл өрхүүдэд мэдээлэл анхааруулга болон сурталчилгааг хүргэн ажиллаж байна.

Мөн Орхон-Сэлэнгийн бэлчир, Орхон, Буурын голуудын гарам, гарц, Хөдөө нуур зэрэг малчид, тээвэрчид, иргэд ихээр зорчдог газруудад Байгаль орчны улсын байцаагч болон Байгаль хамгаалагч нар эргүүл, хяналт хийж хууль бус хайрга олборлох нь ихэссэн тул зөвлөмж, санамж өгч хяналт тавин ажиллалаа. Мөн 04 дүгээр 01-ний өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдрийг дуустал загасны үржлийн үе буюу загас агнах хориотой үе бөгөөд хориотой үед загас агнахгүй байх талаар зурагт хуудсыг Сүхбаатар сумын ЗДТГын самбар болон цахим хаяг, аймгийн хамгийн их гишүүнтэй цахим хаягуудад байршуулан ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/70 тоот захирамжийн хэрэгжилтийг ханган ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сэрэмжлүүлэг мэдээ, сурталчилгааг сумын Байгаль орчны самбар болон Сүхбаатар сумын цахим хуудсаар дамжуулан иргэдэд хүргэн ажиллаж байна.

2021 онд Сүхбаатар суманд Голт бор, Шар хуайс, Тэхийн шээг, Монос, Үрэл зэрэг модны төрлийг тарихаар бэлтгэл ажил эхэлсэн байна.

#### **Түшиг сум:**

Улсын Онцгой комиссын шийдвэрээр 04 дүгээр сарын 10-25-ны өдөр хүртэл хөл хорио тогтоосонтой холбогдуулан сумын хэмжээнд хүнсний дэлгүүрүүд болон эмийн сангийн үйл ажиллагаа цагийн хязгаартай ажиллаж байна. Мөн шатахуун түгээх станц зөвхөн Сумын Онцгой комиссын зөвшөөрөлтэй иргэдэд шатахуун олгож байна.

Суманд 03 дугаар сарын 30-ны өдөр Коронавирусын анхны тохиолдол бүртгэгдэж, 04 дүгээр сарын 01-ний өдөр аймгийн Онцгой комиссын шийдвэрээр томилогдсон “Оношилгооны 10 баг” суурин 3 цэг, явуулын долоо нийт 10 хэсэгт хуваагдаж 12 наснаас дээш бүх иргэнийг шинжилгээнд хамруулахаар ажиллалаа.

Үүнд: Сумын төвийн 830, хөдөөгийн 305, нийт 1135 иргэнийг түргэвчилсэн оношилгуураар хамруулж, 22 тохиолдол эерэг гарсан. Батлагдсан тохиолдлын ойрын хавьтлыг тодорхойлж, давхардсан тоогоор 900 гаруй иргэнийг өдөр бүр PCR шинжилгээнд хамруулж, 04 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл 79 тохиолдол бүртгэгдсэнийг тусгаарлан аймгийн Нэгдсэн эмнэлгийн Ковидын эмчилгээний тасагт шилжүүлж эмчилгээнд хамрууллаа. Батлагдсан хүмүүсээс 69 хүн гэрийн тусгаарлалтад шилжсэн.

“Ковид-19” өвчний тархалтыг бууруулах зорилгоор төр, төсвийн байгууллагын албан хаагчид эргүүл хийж, гудамж талбайд хүмүүсийг хөдөлгөөнийг хязгаарлаж, гэртэй байхыг зөвлөн, 24 цагаар хяналт тавин ажиллаж байна.

“Түшиг соёлын төв” цахим группд сурагчдын заавал унших зохиолуудыг цувралаар оруулж, мөн уншигчдын оюун хэрэгцээнд зориулж цахимаар уран зохиолын бүтээлүүд хүргэж нийт 120 хүн үзсэн байна.

Хичээл сургалтын үйл ажиллагааг 04 дүгээр сарын 31-нийг түр зогсоосон байгаатай холбогдуулан цахим хичээлийг дунд, ахлах ангийн багш нар хуваарийн дагуу орж байна.

Хөгжлийн шийдэл төрийн бус байгууллагаас бизнес эрхлэгч иргэн, ААНБ-уудад зохион байгуулсан “Төсөл боловсруулах арга зүй” сэдэвт цахим сургалтад сумын 15 иргэнийг хамруулсан.

Тус сард 12 өрх, 9 байгууллага, худалдаа үйлчилгээний газрын давхардсан тоогоор 17589 м2 талбайд ариутгал халдваргүйтгэл хийж ажилласан.

Эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдийн орчин нөхцөлд үнэлгээ хийн хариу арга хэмжээ авч, 28 өрх гэр бүлийг хамтарсан багийн гишүүд хяналтад авч ажиллаж байна. Мөн хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлд нөхцөл байдал тулгарсан үед хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг шуурхай үзүүлэх, хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвөөс шилжиж ирсэн 2 удаагийн зорилтот дуудлагыг шийдвэрлэж ажилласан.

#### **Хушаат сум:**

Коронавируст халдварын тохиолдол суманд бүртгэгдсэнтэй холбогдуулан А/37, А/39 тоот захирамжуудыг гарган 04 дүгээр сарын 18-29-ний өдөр хүртэл 10 хоногийн хугацаанд сумын төвийн хөдөлгөөнийг хатуу хориглон Орхон голын постоос гадна сумын төвөөс гарах орох чиглэлд 4 явуулын пост, төвийн эргүүлийг ажиллууллаа. 04 дүгээр сарын 18-ны өдөр Улаанбаатар хотоос ирж гэрийн тусгаарлалтад байхдаа илэрсэн тохиолдлын ойрын хавьтал 22 иргэнийг тусгаарлан түргэвчилсэн шинжилгээнд 2 удаа, PSR шинжилгээг 1 удаа авч бүгд сөрөг гарсан. Коронавирусыг өвчилсөн 4 иргэнийг аймгийн Нэгдсэн эмнэлэгт хэвтүүлэн эмчлүүлээ.

Хүнсний дэлгүүр, эмийн сангийн үйлчилгээг сумын төвийн эргүүлүүд болон хүнсний дэлгүүрүүдийн хүргэлтийн үйлчилгээгээр бүх өрхүүдийг ханган ажиллалаа. Ундны усаа нийтийн худгаас авдаг өрхүүдэд усыг хүргэж өгч үйлчиллээ.

04 дүгээр сарын 06-ны өдөр хамрагдах шаардлагатай 244 иргэнд Синофарм компанийн Vegercell вакцинд хамруулсан ба 05 дугаар сарын 01-ний өдөр 244 иргэнийг давтан тунд хамруулахаар ажиллаж байна.

Сумын хэмжээнд вакцинжуулалтад тариаланч ногоочид нийлсэн 122 иргэнийг хамруулж ажиллалаа.

Нийтийн эзэмшлийн 12 цэгт нийт 5200 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж гүйцэтгэжээ.



Халдвар, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хорогдсон малын хүүр сэг зэм устгах ажлыг зохион байгуулж 1 үхэр, 2 хонь, 1 ямааны хүүр сэг зэмийг цуглуулан устгал хийж ажилласан. Шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг 13000 толгой хурга, ишигт хийж хяналт тавин ажилласан.

#### **Хүдэр сум:**

2021 оны Эрх зүйн сургалт сурталчилгааны төлөвлөгөөний дагуу “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль”-аар Huder ZDTGazar фэйсбүүк хуудсаар цахим сургалтыг зохион байгуулж 157 иргэн үсэн байна.

Тайлант онд аймгийн хөрөнгө оруулалтаар 1, сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 5, орон нутгийн хөгжлийн сангаар 5 нийт 11 хөрөнгө оруулалтын ажлыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Аймгийн Онцгой байдлын газрын даргын 2021 оны “Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамж”-ийн дагуу зам гүүрийн ус зайлуулах 3 суваг, далан бөглөрсөн, ус зайлуулах далан, суваг, шуудуу задарснаас үүдэн айл өрх, дулааны шугамууд, албан байгууллага (Соёлын төв, цэцэрлэг, ЭМТ, Цахилгаан түгээх станц)-ын барилга байгууламж усанд автсан тул шар усны үерийн урсгалын гольдролыг өөрчлөх, далан босгох, барилга дотор орсон усыг соруулж асгах зэрэг шуурхай арга хэмжээг цаг алдалгүй авч ажилласан. Сумын эрүүл мэндийн төвийн барилга руу орсон шар усны үерийг мэргэжлийн ангийн механикжсан бүлгийн гишүүд хайрга, шороо, шланк /нүүрсний хаягдал/-ыг татан авч шар усны урсгалыг зогсоох далан босгон хамгаалж дахин шар усны үер орохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан.

Сумын Засаг даргын 2021 оны А/51 тоот захирамжийн дагуу “Хоггүй орчин нийтийн цэвэрлэгээ”-ний ажлыг сумын хэмжээнд зохион байгуулж, төр, төсвийн 7 байгууллагын 99 албан хаагч, худалдаа үйлчилгээ эрхэлдэг 24 иргэн, мод модон материал боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 10 аж ахуйн нэгжийн 30 ажилчин, “Хүдэр Тохижилт” ОНӨААТҮГ-ын 5 ажилчин, хүнсний талонд хамрагддаг 8 иргэн, сумын 1,2-р багийн 14, нийт 180 иргэн байгууллага, аж ахуйн нэгж орчмын 50 м2 талбай болон нийтийн эзэмшлийн 8 хэсэг, хогийн цэгийн 7 га газрын хог хаягдлыг цэвэрлэж зөөвөрлөн тээвэрлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

Бог малын хээлтүүлэгчийг ялган маллуулах хүсэлтэй 6 иргэний өргөдлийг хүлээн авч засаг даргын зөвлөлөөр хэлэлцэн Баянцагаан 2-р багийн иргэн Ч.Батхишигт өгч маллуулахаар шийдвэрлэж 104 малчин өрхөөс 135 бог малын хээлтүүлэгчийг ялган суурилуулаад байна.

Сумын нөөцийн өвсийг мал бүхий 19 иргэнд 700 боодол өвсийг хямдралтай үнээр борлуулж 2100,0 мянган төгрөгийн орлого оруулсан байна.

Сумын хэмжээнд 16410 мал төллөхөөс 9250 буюу 56,3 хувь нь төллөсөн байна

Коронавирусын вакцинд хамрагдах 4 ААН-ийн 38 тариаланч, 55 ногоочдыг судалгааны дагуу 1-р тунгийн вакцинжуулалтад хамрууллаа.

Улаанбаатар хот, Дархан-Уул аймгаас ирсэн 2 ААН-ийн 8 иргэнийг тусгаарлалтад авч, хяналт тавьж ажиллалаа.

Эрүүл мэндээ хамгаалж Эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд 04 дүгээр сарын байдлаар “Ажлын байр дэмжих зээл”-нд сумын хэмжээнд Хаан банкнаас 1 аж ахуй нэгж 200,000,0 сая төрөг, Төрийн банкнаас 6 иргэн 259,600,0 сая төгрөгийн зээл олгосон байна.

Ариутгал халдваргүйтгэлийн хамтарсан баг /COVID-19/ халдвараас урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэх ажилд 3 автомашин 280 м2, сумын төвд үйлчилгээ явуулдаг 18 цэгт 2300 м2, худаг уст цэг 16 м2, өвөлжөө 1 цэгт 450 м2 нийт 3046 талбайд ариутгал халдваргүйтгэлийг хийлээ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 08 дугаар тогтоолоор суманд хэрэглээний 4400 м3, түлээний 9405 м3 нийт 13805 м3 мод хуваарилагдсаны дагуу сумын ИТХ-ын 2021 оны өдрийн 27 дугаар тогтоолоор 13805 м3 модыг ойн менежментийн төлөвлөгөөний дагуу 23 ААН, 2 багийн хэрэгцээнд хуваарилан баталсан. Үүний дагуу сумын Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/11 тоот Ойгоос хэрэглээний болон түлээний мод бэлтгэх ажлыг зохион байгуулах тухай захирамж гарч мод бэлтгэлийн үйл ажиллагааг зохион байгуулан 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар мод бэлтгэл, хэрэглээний мод 3380 м3, түлээний 3133 м3 мод бэлтгэгдэж гүйцэтгэл 47,1 хувьтай байна.

Үүнийг хэрэглээ түлээгээр нь ялгаж үзвэл:

1. Хэрэглээний мод 4400 м3 –ээс 3380 м3 бэлтгэгдэж 76,8 хувь
2. Түлээний мод 9405 м3-ээс 3133 м3 бэлтгэгдэж 33,3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Иргэд, олон нийт, аж ахуйн нэгж байгууллага, нөхөрлөлүүдэд хүдэр сум Ойн анги, хүдэр зар цахим хуудсаар ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, авах арга хэмжээ зөвлөмж, мэдээ мэдээлэл, постеруудыг видео болон бичмэл хэлбэрээр хүргэж, 3 төрлийн гарын авлага 300 ширхгийг “Нүхэн гүүр”, “Цэнхэр гүүр” хяналтын цэгүүдэд хүргүүлэн ажиллалаа.

Аймгийн МХГ-ын даргын баталсан 2021 оны 18/02 тоот “Хяналт шалгалт хийх тухай” байнгын удирдамж, сумын Засаг даргын 2021 оны А/39 тоот “Ойд үйл ажиллагаа явуулахыг зогсоох тухай” захирамжийн хүрээнд хяналт шалгалтын ажлыг 3 удаа хийж, 21 мэргэжлийн байгууллага хамрагдсан. Зөрчлийн тухай хууль зөрчсөн компаниудад Зөрчлийн хэрэг үүсгэн шалган ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Хуш модны самрын хууль бус бэлтгэлийг таслан зогсоох тухай” А/103 тоот захирамжийн хүрээнд холбогдох байгууллага, алба хаагчидтай хамтран орон нутагт 3-р чиглэлд үүрэг гүйцэтгэн ажиллаж худалдаа үйлчилгээ эрхэлж байсан 4 вокзал болон орон нутгийн 9 иргэн бусад аймаг сумын 143 иргэнийг албадан буулгаж, бүртгэлжүүлэн орон нутаг руу буцаах арга хэмжээ авч ажиллаж байна.

#### **Цагааннуур сум:**

Сумын Шуурхай штабт Засаг даргын Тамгын газрын албан хаагчид 24 цагийн ээлжээр ажиллан, цаг үеийн мэдээллийг иргэдэд хүргэн, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Бүдүүний гүүрний постод 36, эргүүл хяналтад 16 төрийн албан хаагч, аж ахуйн нэгжийн ажилчид хамтран үүрэг гүйцэтгэж байна.

Бүдүүний гүүрний постоор орсон, гарсан тээвэр болоод иргэдийн тоон үзүүлэлт давхардсан тоогоор сум руу орсон 134 тээврийн хэрэгсэл, 258 иргэн, сумаас гарсан 218 тээврийн хэрэгсэл, 437 иргэн байна. Өдөрт дунджаар 6 тээврийн хэрэгсэл, 11 иргэн сум руу орж, 9 тээврийн хэрэгсэл 19 иргэн сумаас гарч байна.

Улаанбаатар хот болон халдварын голомттой бүс нутгаас 104 ирснээс 14 өрхөд, гэр бүлийн гишүүдийн хамт 35 иргэн тусгаарлагдсан байна.

Сумын хэмжээнд 04 дүгээр сард 15 байгууллагын 330404 м2 талбайд ариутгал халдваргүйтгэл хийсэн байна.

/Ковид-19/ халдварын эсрэг вакцинжуулалтад хамруулахаар заагдсан 649 иргэнийг 100 хувь хамруулж ажиллалаа.

“Дэлхийн усны өдөр”, “Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгуулж хэвшүүлэх” аяны хүрээнд 15 төрлийн мэдээллийг бэлтгэн цахим хуудаст байршуулсан.

04 дүгээр сард шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажил эхэлж гүйцэтгэл 50 хувьтай байна. Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд боловсруулалтад бод 3660, бог 13450, туулгалтад бог 2550, бод 449, нохой 142 толгой мал амьтан хамруулсан байна. Халдваргүй өвчний 175 удаагийн дуудлага ирсэн.

Энэ онд гүү 860, үнээ 4580, эм хонь 25600, эм ямаа 18700 төллөж, тугал 4, хурга 40, ишиг 94 хорогдон, унага 860, тугал 4576, хурга 25560, ишиг 18606, нийт 49602 төл бойжиж байна. Төллөлт 58,3 хувь, төл бойжилт 99,1 хувьтай байна.

1-р багийн 91 өрхийн 250 иргэн, 2-р багийн 47 өрхийн 170 иргэн, 3-р багийн 85 малчин өрхийн 220 иргэнд “Ойн тухай хууль”, “Хог хаягдлын тухай хууль”, түлээний мод бэлтгэхэд анхаарах зүйлс, “Ойн дагалт баялаг, жимс жимсгэний тухай, Ан амьтны тухай хууль”-аар САНАМЖ хуудас бэлтгэн тарааж ой хээрийн болон объектын гал түймрээс урьдчилан сэргийлэх ажиллалаа.

Сумын Засаг даргын А/26 тоот захирамжаар бүх нийтийн цэвэрлэгээг сумын хэмжээнд зохион байгуулж нийтийн эзэмшлийн зам талбайг цэвэрлэж 8 тн хог хаягдлыг хогийн нэгдсэн цэгт ачиж буулгасан.

#### **Шаамар сум:**

Монгол Улсын Засгийн газрын 45 дугаар тогтоол “Коронавируст халдвар (Ковид-19) цар тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”, Засгийн газрын 2021 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 91 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 18 дугаар тушаал “Коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай түр журам”, Улсын Онцгой комиссын 2021 оны “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 2 дугаар тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллалаа.

Аймгийн Засаг даргын А/15 дугаар “Бүх нийтийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх тухай” захирамжийг хэрэгжүүлэн Шаамар сум, Дулаанхаан тосгоны төр төсвийн болон хувийн ААН-ийн нийт 32 байгууллагын 10586,2 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт их цэвэрлэгээг хийлээ.

Сумын хэмжээнд эргүүл хяналтыг 2 хүний бүрэлдэхүүнтэйгээр, шуурхай штабыг 24 цагаар тус тус ажиллуулж байна. Сумын хэмжээнд Улаанбаатар хотоос 1 тээврийн хэрэгсэлтэй, эрсдэл бүхий сумаас ирсэн 3 тээврийн хэрэгсэлтэй, нийт 16 хүнийг халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зөвлөмжийн баталгааны маягт бөглүүлэн нийт 7 өрхийн 16 том хүн хамт байгаа өрхийн гишүүдийн тоо 11, нийт 27 хүн гэрийн ажиглалтад байна.

Аймгийн Засаг даргын А/108 дугаар “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” захирамжийг хэрэгжүүлэн коронавирусын /Ковид-19/-ын тархалтын түвшинг сумын хэмжээнд тогтоож, холбогдох арга хэмжээ авч төлөвлөгөө боловсруулан ажилласан.

Мөн Аймгийн Онцгой комиссын 11 дүгээр тогтоолын дагуу Сэлэнгэ аймагт “Улаан” түвшинд шилжсэнтэй холбогдуулан харилцаа, холбоо, шуудан, эрүүл мэндийн яаралтай үйлчилгээ, эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх үйл ажиллагаа, хүнс, шатахуун түлш болон өвс, тэжээлийн тээвэрлэлт, түгээлт, газар тариалан, уул уурхай,

зам, барилга, эрчим хүч, инженерийн байгууламж, оршуулгын үйл ажиллагааны хөдөлгөөнийг сумдын Онцгой комиссын зөвшөөрлийг үндэслэн аймгийн Шуурхай штабын зөвшөөрлөөр нэвтрүүлэн ажиллаж байна.

Аймгийн засаг даргын А/26 тоот захирамж, сумын засаг даргын А/70 тоот захирамжийн хэрэгжилтийн хүрээнд “Ойн хээрийн түймэр”-ийн эргүүл шалгалтыг тогтмол хийж 70 иргэнд анхааруулга санамжийг тарааж 11 ААНБ-д захирамж тараан ойн хээрийн түймрийн тодотгол хийн 1,2-р ээлжид ажиллах албан хаагчдыг тодотгон ажиллалаа.

Шаамар 6 км-ээс Сүхбаатар самбар хүртэлх 2.5 км замын орчмыг ЗДТГ-ын зургаан албан хаагч, төв хогийн цэгт зорилтот бүлгийн 8 иргэн, холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран 1.5 тн хог 32 ширхэг золбин нохой, үхэр 16, адуу 24, хонь 30 ширхэг сэг зэмийг ариутгал хийн устгалд оруулсан.

Байгалийн эсрэг гэмт хэргийн эргүүл шалгалтыг тогтмол хийж бойны тохой, 28-н гарам зэрэг газраас зохих зөвшөөрөлгүй хоёр иргэнийг журамлан “Зөрчлийн тухай” хуулиар тус тус 200.0 мянган төгрөгөөр торгон төрийн санд төвлөрүүлэн ажилласан.

Коронавируст халдварт /Ковид-19/ цар тахал гарсантай холбогдуулан “Дэлхийн Зөн Монгол” ОУБ-аас цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан халдвараас урьдчилан сэргийлэх, хүүхэд багачуудыг дархлаажуулах, амьжиргааг дэмжихэд чиглэсэн хүмүүнлэгийн арга хэмжээг зохион байгуулж, уг ажлын хүрээнд сумын 1,2 дугаар багийн хэмжээнд 120 өрхөд тус бүр 100,0 мянган төгрөг нийт 12,000,0 төгрөгийн хүнсний тусламж үзүүлсэн.

Хүүхдүүдийг осол гэмтэл, аливаа хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үүднээс аймгийн Засаг даргын 2021 оны А/81 тоот захирамжийн хүрээнд сумын хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүд 7 хоногийн хугацаанд хуваарийн дагуу оройн цагаар гудамж, хэсгүүдэд хөдөлгөөнт эргүүлээр ажиллаж, иргэдийг хөршийн холбоогоо сайжруулах, хөрш айлд нь харгалзах хүнгүй хүүхэд байгаа, хэн нэгэн хүчирхийлэлд өртөж байгаа тохиолдолд бидэнд мэдээлж ажиллах талаар мэдээлэл бэлтгэн сумын цахим хуудсанд байршуулсан.

Иргэд олон нийтэд төрийн байгууллагаас зохион байгуулсан ажил арга хэмжээний талаарх мэдээ, мэдээллийг сумын цахим хуудсаар дамжуулан хүргэж байна.

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

ГАЗРЫН ДАРГА

Ө.СУВДАА

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

МЭРГЭЖИЛТЭН

Д.АЛТАНТУЯА